

Монгол орны загасны Улаан данс

Редактор **Ж. Осок, Г. Баасанжав,**
Ж. Е. М. Baillie, М. Эрдэнэбат,
М. Kottelat, Б. Мэндсайхан, К. Smith

Өмнөх үгийг **М. Lovei & S. D. Meyanathan**

Удиртгал хэсгийг **М.Эрдэнэбат**



THE WORLD BANK



Royal Netherlands Embassy



Энэхүү бүтээл нь Дэлхийн Банкнаас Хүрээлэн буй орчны шинэчлэлд зориулсан Нидерланд-Монголын Итгэлцлийн сангийн санхүүжилтээр ивээн тэтгэгдсэн.

Уг бүтээлд нийтэлсэн ололт, нээлтүүд, тайлбар, дүгнэлт нь тухайн бүтээлийг туурвисан зохиогчдын санал, илэрхийлэл байсан бөгөөд, Олон Улсын “Сэргээн босголт, Хөгжлийн Банк”-ны Бүйцэтгэх Захирал (Дэлхийн Банкны удирдах албан тушаалтан)-ы үзэл бодлыг тусгаагүй болно.

Энэ номонд оруулсан мэдээ баримтын бодит үнэнийг Дэлхийн Банк баталгаажуулахгүй. Уг бүтээлийн аливаа нэг газрын зураг дээр дүрсэлсэн хил хязгаар, өнгө будаг, нэр болон бусад мэдээлэл нь аль нэг нутаг дэвсгэрийн хууль цааз эсхүл тухайн хил хязгаарыг баталгаажуулсан баримт бичигтэй холбогдох Дэлхийн Банкны тодорхой нэг бүлгийн үзэл бодол, шийдвэрийг илэрхийлээгүй болно.

Дэлхийн Байгаль Хамгаалах Холбоо (IUCN) нь Монгол орны загасны Улаан дансыг хэвлэн нийтлэхийг дэмжиж өөрсдийн мэргэжилтэн болон шаардлагатай мэдээ баримт бусад техник туслалцаагаар хангасан болно. Хэдийгээр тус холбоо Монгол орны загасны Улаан дансыг хэвлэх ажлыг дэмжиж байсан ч уг номонд тусгагдсан мэдээ баримт нь Дэлхийн Байгаль Хамгаалах Холбооноос баримталж буй үзэл баримтлалыг төлөөлөөгүй болно.

Хэвлэлд бэлтгэсэн: Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Регентс Парк, Лондон, NW1 4RY

Зохиогчийн эрх: © Лондоны амьтан судлалын нийгэмлэг болон ивээн тэтгэгч 2006. Бүх эрх хамгаалагдсан.

Энэ бүтээлийн аль нэгэн хэсгийг зөвхөн арилжааны бус зорилгоор ашиглах болон хэвлэн олшруулахдаа эх сурвалжийг нь дурдаж талархал илэрхийлсэн байх ёстой.

ISSN: 1751-0031

Иш баримт: Осок, J., Баасанжав, Г., Baillie, J. E. M., Эрдэнэбат, М., Kottelat, M., Мэндсайхан, В., Smith, K. (Эмхэтгэсэн, Редактор) (2006). *Монгол орны загасны Улаан данс*. Бүх нутгийн Улаан данс цуврал. Боть. 3. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Лондон. (Англи, Монгол хэл)

Түлхүүр үг: Улаан данс, устах эрсдэл, загас, Монгол, хамгааллын зэрэг, ховордол

Хэвлэсэн: АДМОН Хэвлэлийн газар, Улаанбаатар.

Нүүр хавтас: Тул (*Hucho taimen*) B. Allen

Энэ номонд оруулсан бүх зүйлийн дэлгэрэнгүй мэдээллийг Монголын Биологийн олон янз байдлын мэдээллийн сангаас авах боломжтой. Энэ мэдээ нь олон нийтийн хэрэгцээнд зориулагдсан бөгөөд уг материалтай холбогдол бүхий мэдээ баримттай танилцах шаардлагатай бол доорхи хүнтэй холбоо барина уу:

Улаанбаатар

Монгол Улсын Их Сургууль

Биологийн Факультет

Амьтан судлалын тэнхим

Н.Батсайхан

Утас: +976 99181899

E-mail: batsaikhan@biology.num.edu.mn ба microtusb@yahoo.com

Уг эмхэтгэл нь цөөн тоогоор хэвлэгдэх боловч энэ тайлангийн электрон хувийг Лондоны Амьтан судлалын нийгэмлэгийн номын сангийн (<http://library.zsl.org>) болон www.regionalredlist.com хаягаар хандан үзэх боломжтой.

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	3
УДИРТГАЛ	5
ТАЛАРХАЛЫН ҮГ	7
УДИРДАМЖ	9
ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ХОЛБООНООС ЭМХЭТГЭН ГАРГАСАН УЛААН ДАНСНЫ ЗЭРЭГЛЭЛ БОЛОН ШАЛГУУРЫГ БҮС НУТГИЙН ТҮВШИНД ХЭРЭГЛЭХ НЬ	11
ТЕХНИКИЙН ТЭМДЭГЛЭЛ	
Ангилал зүй ба нэршил	14
Бүс нутгийн тархалт: Монголын ус судлал	15
Зүйлийн газар зүйн зураг	16
ЗҮЙЛИЙН ДАНСНЫ ЗАГВАР	17
МОНГОЛ ОРНЫ ЗАГАСНЫ ЗЭРЭГЛЭЛ	19
МОНГОЛ ОРНЫ ЗАГАСНЫ ТАРХАЛТ	21
МОНГОЛ ОРНЫ ЗАГАСНЫ ХОРОГДОЛ	23
ЗҮЙЛИЙН ЖАГСААЛТ	
Дугариг амтан	25
Хилэмтэн	26
Мөрөгтөн	28
Цулбууртан	48
Яргайтан	49
Цурхайтан	55
Сагамхайтан	56
Живэртэн	57
Алганатан	59
НОМ ЗҮЙ	60
ХАВСРАЛТ	
I. А-Е шалгуурын эмхэтгэлийг Устаж байгаа, Устаж болзошгүй, Эмзэг зүйлүүдэд хорогдлын зэргийг тооцоолохдоо ашигласан (IUCN-н дүгнэлт (2001))	62
II. Жагсаалт 1: Монголын биологийн олон янз байдлын мэдээллийн сангийн ажлын хэсгийн уулзалтын явцад үнэлгээ нь хийгдсэн Монголын нутаг дэвсгэрт тохиолддог зүйлүүд. Жагсаалт 2: Монголын нутаг дэвсгэрт тохиолдох боломжтой болон шинээр олдсон зүйлүүд	63

ӨМНӨХ ҮГ

Монгол орны загасны улаан данс нь Дэлхийн банкнаас Хүрээлэн буй орчны шинэчлэлд зориулсан Нидерланд-Монголын Итгэлцлийн сангаас явуулж буй үйл ажиллагааны үр дүнд хэвлэн нийтлэгдсэн бүтээлүүдийн нэг юм. Үүний өмнөх боть болох Монголын хөхтөн амьтны улаан данс нь хамгийн чухал гэгдэх зэрлэг амьтдын бүлгүүдийн талаарх үндсэн ойлголтыг танилцуулсан бөгөөд, Maurice Kottelat Монгол орны загас: ‘Монгол орны загасны ангилал зүй, нэршил, түүнд өгөх зөвлөмж’ загасны нэрсийн толь бичгийн бүрэн эхийг хийж гүйцэтгэх юм.

Энэ номыг хэвлэх ажилд маш олон талын дэмжлэг авах боломж олдсонд бид их баяртай байна. Тухайлбал, энэхүү үйл ажиллагаанд оролцсон Монгол Улсын Их Сургууль, Монголын Шинжлэх Ухааны Академи, Байгаль Орчны Яам, Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Степ Форвард Программ зэрэг байгууллага, нэгжээс үзүүлсэн гайхамшигтай хичээл зүтгэлд бид талархаж байна. Хустайн Байгалийн цогцолбор газарт зохион байгуулсан ажлын хэсгийн уулзалт нь маш өргөн хүрээний мэдээлэл цуглуулах эх үүсвэрийг тавьсан нь энэ төслийн цаашдын ажилд урьд өмнө нь төсөөлж байгаагүй үнэтэй хувь нэмрийг оруулсан юм. Гэхдээ бүх зүйлийн талаарх нарийвчилсан мэдээлэл хайх явцад мэдээлэл олдохгүй байх эсвэл учир дутагдалтай мэдээлэл олдох зэрэг асуудал тулгарч байсан боловч бид эдгээр асуудлыг цаашдын судалгаандаа анхаарах шаардлагатайг дурьдаж өгсөн.

Цэвэр усны биологийн олон янз байдлыг хуурай газрын биологийн олон янз байдалтай харьцуулахад үндсэндээ ядмаг байх ба загас, тэдгээрт нүүрлэж буй аюул заналыг онцлон тэмдэглэж, хамгаалах мөн зүй зохистой менежментийг хэрэгжүүлэхэд шаардагдах арга хэмжээг авах, түүнчлэн Монгол орны хувьд гадаргын усны, тухайлбал, далан, шуудуу татах, уурхайн ажил, усыг шилжүүлэн хэрэглэх зэрэг бодлогын талаар хэрэгжиж буй төслийн хүрээнд, хүрээлэн буй орчны үнэлгээ хийхэд шаардагдах баталгаатай лавлах материал бий болгож өгснөөр загасны судалгааны ажлын хүрээ өргөжин тэлнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Magda Lovei
Environment Sector Manager
The World Bank
Washington D.C.
USA

Saha Dhevan Meyanathan
Mongolia Country Manager
The World Bank
Ulaanbaatar
Mongolia

УДИРТГАЛ

Монгол улс нь амьтны газарзүйн байршлын хувьд өвөрмөц мужид хамрагдах Төв Азийн хээрт оршдог бөгөөд тус улс нь Төв Азийн усны 3 үндсэн систем болох Хойд мөсөн далайн ай сав, Номхон далайн ай сав буюу Амар мөрний сав, Төв Азийн гадагш урсгалгүй гол мөрний ай савуудыг багтаадаг. Монгол нь хуурайсаг орны тоонд ордог ч хэд хэдэн том гол, нууруудтай. Монгол орны загасны талаарх мэдээлэл дутмаг.

Тул (*Hucho taimen*) болон зэвэг (*Brachymystax lenok*) загасыг нээж, шинж тэмдгийг нь тодорхойлон бичиглэлийг нь хийсэн Германы байгаль судлаач Peter Simon Pallas 1700-аад оны сүүлээр Монгол орны загасны анхны цуглуулгыг хийсэн. Үүний дараагаар нэрт эрдэмтэн В. Dybowski, S.Basilewsky болон К. Kessler нарын судалгаагаар хэд хэдэн зүйлийн дүрслэлийг тодорхойлсон. 1900 оны эхээр Leo Berg Монголын болон Оросын загасны судалгааг нилээд эрчимтэй хийсэн. 20 дугаар зууны 2 дугаар хагаст Зөвлөлт-Монголын, Чехословак-Монголын, Герман-Монголын хамтарсан маш олон тооны хээрийн судалгааны ангиуд монгол оронд ажиллаж судалгаа, шинжилгээ хийж, Монгол орны байгалийг өргөн хүрээнд цогц байдлаар судлахыг зорилго болгож байсан ба загас судлалын чиглэлд судалгаанд хэрэглэх ихээхэн шинэ цуглуулга хуримтлуулсан. 1947 онд Монгол Улсын Их Сургуулийн Амьтан судлалын тэнхимийг тэргүүлж байсан анхны Монгол эрдэмтэн, профессор А. Дашдорж Монголын загасны тусгайлсан судалгааг хийж гүйцэтгэж байсан. Учир нь профессор А. Дашдорж тухайн үедээ усны амьтан судлалыг илүү сонирхож байжээ. Г. Баасанжав Я. Цэнд-Аюуш нарын 2001 онд хэвлүүлсэн 'Монгол орны загас' (Монгол хэл дээр хэвлэгдсэн) ном нь Монгол орны загасны ангилал зүйн чухал мэдээ, тоймыг тусгаж өгсөн байдаг. Түүнчлэн энэ ном нь бүс нутгуудад тохиолдох загасны биологи болоод агнуурын аж ахуйн талаарх мэдээг нэгтгэж өгсөн байдаг. Үүний өмнө 'ЗХУ болон түүний зэргэлдээх нутаг дэвсгэрийн цэвэр усны загас' (1949 онд орос хэл дээр, 1962 онд Англи хэл дээр хэвлэгдсэн) сэдэвт бүтээл нь Монгол орны загасны үндсэн лавлах материал болж байсан. Барууны судлаачдад Монгол орны загасны тухай асуудал тодорхой бус байх үед 1980-аад оны дунд үеэр Robert Travers усны амьтны судалгааг хийсэн. Сүүлийн үед Америкийн хэд хэдэн Их сургуулиуд Тул хамгаалах нийгэмлэгтэй хамтран тул загасыг тогтвортойгоор хамгаалах урт хугацааны судалгааг зохион байгуулсан.

Монголын Биологийн олон янз байдлын мэдээллийн сангаас зохион байгуулсан мэргэжлийн бүлгийн уулзалт нь Монгол орны хувьд одоогоор хуримтлагдаад байгаа загасны мэдээллийг олон улсын жишиг, тухайлбал, амьтны нэршлийн олон улсын кодтой нийцүүлэх асуудлыг хэлэлцсэн. Мөн энэхүү ажлын хэсгийн чуулга уулзалт усны амьтан судлаачдад Дэлхийн байгаль хамгаалах нийгэмлэгийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах боломжийг нээж өгсөн. Мөн олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн ховордлын зэрэглэл, шалгуурыг анхны удаа Монгол орны загасанд хэрэглэсэн тохиолдол болж тэмдэглэгдсэн.

Монгол орны загасны ихэнхи судалгаа, мэдээллүүд голчлон эдийн засгийн ач холбогдол бүхий зүйлийн хувьд чиглэгдсэн байдаг. 1990 онд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг доройтон унасан үеэс хойш загасны аж ахуйн бүтээгдэхүүний талаар цөөн мэдээлэл хуримтлагдах болсон. Монгол орны хувьд болон бусад орнуудын хувьд ч мөн адил Монгол орны загасны хэрэгцээ улам нэмэгдсэний улмаас бүс нутгийн хэмжээнд хуулиар хамгаалагдсан хэдий ч хууль бусаар агнах явдал гарсаар байна. Түүнээс гадна уур амьсгалын өөрчлөлт болон алт олборлолтын үйл ажиллагааны явцад Монголын загас их хэмжээгээр хорогдсоор байна.

Энэ бүтээлийн агуулгад тусгагдсан ажлын хэсгийн шинжээчдийн үнэлгээ Монголын загасны өнөөгийн байр суурийг тоймлон тусгаж өгсөн. Энэ бүтээл монголд тархсан загасны 64 унаган зүйлд тулгараад байгаа бэрхшээл болон газар зүйн тархалтын талаарх боломжит бүх мэдээлэлийг багтаасан болно. Түүнчлэн эдгээр загасны талаар өнөөг хүртэл бидний олж мэдээгүй байгаа асуудал болон цаашид нэн түрүүнд ямар судалгаа хийх шаардлагатайг тодорхойлж өгсөн. Энэ ном хэвлэгдэн гарснаар зөвхөн Монгол орны загасны талаарх бидний ойлголтонд өөрчлөлт орох төдий бус загасны бүх зүйлүүдийг хамгаалахад тодорхой хувь нэмэр оруулна гэдэгт бид чин сэтгэлээсээ итгэж байна.

*Манчингийн Эрдэнэбат
Шинжлэх Ухааны Академи
Гео-Экологийн хүрээлэн*

ТАЛАРХАЛЫН ҮГ

Монголын усны амьтан судлалд хүч, оюун ухаанаа зарцуулсан цөөн тооны эрдэмтдийн туслалцаагүйгээр энэ номыг эмхэтгэж, хэвлэх бололцоогүй байсан юм. Монгол орны загасны улаан дансыг хянан толилуулсан профессор А. Дулмаад талархаж байгаагаа тусгайлан илэрхийлье. Түүнчлэн энэхүү улаан дансыг хянахад гар бие оролцон өөрийн санал бодлоо илэрхийлж, цаашдын мэдээ баримтаар хангаж байсан Zeb Hogan, Jake Vander Zanden, David Gilroy (Монголын тул (*Hucho taimen*) төсөл), Andrew Parkinson (Монгол загас) болон Samuel Turvey (Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг) нарт талархаж байгаагаа илэрхийлье. Түүнчлэн ‘Тул хамгаалах сан’-гаас үзүүлсэн арвин их зөвлөмж, туслалцаанд бид баярлаж байгаагаа илэрхийлье. Монголын Биологийн олон янз байдлын мэдээллийн сангийн ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулахад идэвхитэй дэмжлэг үзүүлсэн Хустайн Байгалийн цогцолбор газрын ажилтан, албан хаагчдад мөн талархалаа дэвшүүлье.

Семинарын явцад орчуулгын ажилд туслалцаа үзүүлсэн О. Чимэдцэрэнд талархаж байна.

Энэ ном нь Дэлхийн банкны үүсгэл санаачилга, санхүүгийн дэмжлэгтэйгээр Лондоны Амьтан судлалын нийгэмлэг (бүс нутгийн хүрээнд Степ Форвард Программ төлөөлж байгаа) болон Монгол Улсын Их Сургууль, Монголын Шинжлэх Ухааны Академи, Байгаль Орчны Яам болон Дэлхийн Байгаль Хамгаалах Нийгэмлэг (IUCN), бүс нутгийн болон олон улсын бусад байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд удирдан гүйцэтгэж буй ‘Монголын Биологийн олон янз байдлын мэдээллийн сан’ төслийн ажлын хүрээнд хийгдсэн бүтээл юм. Иймд бид ‘Монголын Биологийн олон янз байдлын мэдээллийн сан’ төсөлд чухал хувь нэмэрээ оруулсан дараах байгууллагуудад тусгайлан талархалаа илэрхийлэхийг хүсэж байна.

Дэлхийн Банк (Бээжин дэх Нидерландын Вант Улсын Элчин Сайдын Яамны санхүүжилтаар) нь Монголын Биологийн олон янз байдлын мэдээллийн сан төслийг анхлан үүсгэн санаачилсан төдийгүй өмнө нь боломжгүй байсан Монгол орны загасны Улаан дансыг хэвлэн нийтлэхэд санхүүгийн ихээхэн тусламж үзүүлсэн юм. Мөн түүнчлэн энэхүү төслийг хэрэгжүүлэх явцад тулгарч байсан бэрхшээлийг шийдвэрлэхэд өөрийн хүч чадлаа харамгүй зориулж байсан Tony Whitten-д онцгойлон талархалаа илэрхийлж байна.

Дэлхийн Байгаль Хамгаалах Холбоо (IUCN) уг номыг туурвих болон холбогдох мэдээ материалыг эмхэтгэхэд голлох үүрэг гүйцэтгэсэн юм. Иймд Дэлхийн Байгаль Хамгаалах Холбооны зүгээс тус номыг хэвлэн нийтлэхэд зориулан өөрсдийн мэргэжилтэн, албан хаагчдыг оролцуулан техникийн зөвлөмж өгч, тус холбооноос гаргасан ховор зүйлийн жагсаалтын зэрэглэл, шалгуур шинж, мэдээ баримтыг ашиглах боломжоор хангаж өгсөнд бид гүнээ талархаж байна. Ялангуяа, бүх зүйл загасны үнэлгээг хийхэд голлох үүрэг гүйцэтгэсэн Дэлхийн Байгаль Хамгаалах Холбооны Цэвэр

усны биологийн төрөл зүйлийн үнэлгээний мэргэжилтэн Kevin Smith-д баярласнаа илэрхийлье.

Лондоны Амьтан судлалын нийгэмлэг (ZSL) нь Монголын Биологийн олон янз байдлын мэдээлэлийн сан төслийг удирдан үйцэтгэсэн Jonathan Baillie (төслийн удирдагч), Emma Clark (төслийн зохицуулагч), Joanne Osock (төслийн зохицуулагч) болон Ben Collen (техникийн зөвлөх) нар бүгд Лондоны Амьтан судлалын нийгэмлэгийн бие бүрэлдэхүүн болно. Түүнчлэн, уг төслийг удирдан чиглүүлж үнэтэй хувь нэмэрээ оруулсан Байгаль хамгаалалийн хөтөлбөрийн удирдах албан тушаалтан Glyn Davies-д талархаж байна.

Степ Форвард Программ (SFP) нь Дарвины (UK DEFRA) санаачилагаар үүсгэн байгуулагдсан төвийн санхүүжилтээр 2003 оноос эхлэн Монголд үйл ажиллагаагаа явуулж байгаа. Монгол Улсын Их Сургуультай хамтран ажилладаг Энэхүү төслийг Лондоны Амьтан судлалын нийгэмлэгээс удирдан зохион байгуулдаг. бөгөөд Монгол Улсын Их Сургуультай хамтран ажилладаг. Энэхүү төсөлд ажилладаг бүх албан хаагчид, ялангуяа төслийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэгч, зөвлөх Sarah King-д болон мэдээлэлийн эх үүсвэрийг эмхэтгэхэд өөрийн урам зориг, арга ухаанаа харамгүй зарцуулсан Шаравын Оюунчимэгт, мөн ажлын хэсгийн уулзалтыг удирдан зохион байгуулахад чухал их үүрэг гүйцэтгэсэн Жамсранжавын Жаргал, Lucy Simpson нарт талархал ж байгаагаа илэрхийлж байна.

Монгол Улсын Их Сургууль (NUM) нь тус ажлын хэсгийн уулзалтыг удирдан зохион байгуулсны зэрэгцээ Степ Форвард Программ Хээр судлалын төв болон Монголын Биологийн олон янз байдлын мэдээлэлийн сангийн үйл ажиллагааг явуулж буй гол үндсэн нэгж байгууллага юм. Монгол Улсын Их Сургууль нь энэхүү төслийг хэрэгжүүлэхэд идэвхитэй оролцож өөрийн дэмжлэг туслалцааг харамгүй үзүүлж байгаа билээ. Энэхүү төслийн үйл ажиллагааг дэмжиж, удирдан чиглүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулсан Равчигийн Самъяад талархаж байгаагаа илэрхийлье.

Монголын Шинжлэх Ухааны Академи (MAS) нь ажлын хэсгийн уулзалтанд мэдлэг оюунаа дайчилж, бүтээлч сэтгэлгээгээр хандан өөрсдийн хувь нэмэрээ оруулсанд бид чин сэтгэлээсээ талархаж байна. Түүнчлэн энэ төслийн үйл ажиллагааг дэмжиж өөрсдийн цаг зав, оюун ухаанаа дайчлан ажилласан бүх судлаачдад талархал дэвшүүлж байгаагаа илэрхийлье.

Байгаль Орчны Яам (MNE) уг төслийг дэмжиж, хэрэгжилтэнд нь анхаарлаа хандуулж байсан билээ. Иймд бидний зүгээс Хяналтын Хорооны хуралдаанд оролцогсод болон ажлын хэсгийн цуглааны явцад идэвхитэй оролцож Байгаль Орчны Яамны бодлогыг танилцуулсанд чин сэтгэлийн талархалаа илэрхийлж байна.

УДИРДАМЖ

Монгол орны загасны тоо толгой хорогдож, мөхөлд хүрч буй талаарх олон мэдээ баримт, нотолгоо урьд өмнө нь дурьдагдаж байсан ч Монголын загасыг хамгаалах үнэлгээний асуудал хэзээ ч хөндөгдөж байгаагүй. Монгол орны загасны улаан данс нь Монголын загасны талаарх бүх мэдээллийг багтаасан төдийгүй тэдгээрийн өнөөгийн нөхцөл байдлыг онцлон тэмдэглэсний зэрэгцээ тархалт, хууль цаазанд тусгагдсан байдал, хорогдлын шалтгаан зэрэг бусад мэдээллүүдийг тусгаж өгсөн. Зарим зүйлийн хувьд дэлхийн хэмжээнд үнэлэгдсэн хамгааллын зэрэг тусгагдсан болно. Ховордлын зэргийн нэр томъёонд (Анхааралд өртөөгүй, Ховордож болзошгүй, Эмзэг, Устаж болзошгүй, Устаж байгаа, Байгаль дээр устсан ба Устсан) зүйлийг зэрэглэхдээ тоо хэмжээний босго үзүүлэлт ашигласан ‘Дэлхийн Байгаль Хамгаалах Холбооноос эмхэтгэн гаргасан Ховор зүйлийн жагсаалтын зэрэглэл болон шалгуурыг’ (IUCN, 2001), ашиглан үнэлгээг хийсэн.

Үнэлгээ хийгдсэн бүх зүйлийг тодорхой дүрслэх, мөн тус оронд нутагших загасны хамгааллын зэрэглэлийг нийтэд мэдээлэх зорилгоор Монгол оронд ховордож байгаа болон одоогоор эрсдэлд өртөөгүй байгаа загасны бүх зүйлүүдийг энэ баримт бичигт оруулсан. Гэхдээ Эмзэг, Устаж болзошгүй, Устаж байгаа гэсэн ангилалд орсон зүйлүүд бараг устаж үгүй болж байгаа гэж үзэж болох бөгөөд албан ёсоор улаан дансанд орсон зүйл хэмээн тэмдэглэсэн.

‘Монгол орны загасны улаан данс’ бүтээл нь Монгол орны загас хамгааллын асуудлын үндэс суурь нь болох бөгөөд тухайн нөхцөл байдал цаашид сайжрах эсвэл улам доройтож байгааг үнэлэх боломжийг бий болгож байгаа юм. Түүнчлэн хорогдож буй загасны зүйлийн талаар бодлого боловсруулахад шаардагдах хамгийн сүүлийн үеийн мэдээллийг оруулсны зэрэгцээ зарим зайлшгүй хийх шаардлагатай ажлуудыг санал болгосон бөгөөд мэргэжлийн байгаль хамгаалагчдад хамгааллын төлөвлөгөө боловсруулахад хэрэгтэй мэдээллийг оруулж өгсөн.

Монгол орны загасны улаан дансыг хэвлэн нийтлэхэд оролцсон мэргэжилтнүүд Монголын Биологийн олон янз байдлын мэдээллийн санд оруулсан загасны төрөл зүйлийн мэдээллийг нэгтгэхэд мөн тус дэм үзүүлсэн. Тухайлбал, МУИС-ийн Амьтан судлалын тэнхим зүйлийн тархалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, экологи, идээшил нутаг, хорогдлын шалтгаан болон хамгаалах арга хэмжээний талаархи боломжит бүх мэдээллээр хангасан. Хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл нь бүх хорогдож буй зүйлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл болон тэдгээрийг цаашид хамгаалан мэнд авч үлдэхэд шаардагдах арга хэмжээг тусгаж өгсөн. Эдгээр хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл тусгай баримт бичиг болон хэвлэгдэх бөгөөд үүний электрон хувилбарыг Лондоны Амьтан судлалын нийгэмлэгийн номын сангийн (<https://library.zsl.org>) болон www.regionalredlist.com хаягаар хандан үзэх боломжтой.

Монгол орны загасны Улаан данс бол зөвхөн анхны алхам нь юм. Энэ нь Монгол орны загасны талаар ямар мэдээлэл байна, бид юу мэдэж байна гэдгийг задлан шинжлэхэд тусласны зэрэгцээ бидний мэдлэгийн хүрээнд дутагдаж байгаа зүйлийг ч мөн тодорхойлж өгсөн. Түүнчлэн Монгол орны загасанд нүүрлэж буй аюул, тухайлбал, хууль бус агналт, өсөн нэмэгдэж буй үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон уур амьсгалын өөрчлөлт зэрэг асуудал нь улам ноцтой болж байгааг тэмдэглэсний зэрэгцээ үндсэн ажиглалт хийхийн ач холбогдлыг онцлон заасан. Мөн сайн судлагдаагүй байгаа зүйлийн талаар судалгаа, шинжилгээг хийж, ангилал зүйн хувьд асуудал нь шийдэгдээгүй байгаа зүйлийг устаж алга болохоос нь өмнө тодорхойлж баталгаажуулах шаардлагатайг дурьдсан. Энэ баримт бичиг Монгол орны загасны хамгаалал болоод судалгаа шинжилгээний ажилд шинэчлэлт хийнэ гэдэгт бид итгэж байна.

ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ХОЛБООНООС ЭМХЭТГЭН ГАРГАСАН УЛААН ДАНСНЫ ЗЭРЭГЛЭЛ БОЛОН ШАЛГУУРЫГ БҮС НУТГИЙН ТҮВШИНД ХЭРЭГЛЭХ НЬ

Улаан данс болон хорогдож буй зүйлийг онцлон тэмдэглэсэн бусад данс бараг 60 гаруй жилийн тэртээгээс анхлан бий болсон (Baillie & Groombridge, 1996). Эдгээр данс нь ангилал зүйн хувьд янз бүрийн хүрээнд хамрагдах зүйлүүдийн устаж буй үйл явцыг үнэлэх чухал арга хэрэгсэл болсон бөгөөд цаашлан ховордож буй зүйлд тавих анхаарлыг нэмэгдүүлэх, тэдгээрийг хамгаалахад нэн түрүүнд хийх шаардлагатай ажлыг тодорхойлж өгдөг (Lamoreux *et al.*, 2003). 1994 онд зүйлийн хамгааллын зэргийг тодорхойлох анхны харьцангуй хийсвэр арга зүйг дэлхийн хэмжээнд устах аюулд өртөөд байгаа зүйлүүдийн нөхцөл байдлаас болж тэдгээрийг ангилаж тодорхой стандартад оруулахад тус дэм болох, тоон шалгуурт оруулж илүү бодитой арга барилаар солисон (Mace, 1994). Эдгээр шинэ шалгууруудыг анхлан '1996 онд Дэлхийн байгаль хамгаалах нийгэмлэгийн ховордож буй зүйлийн улаан дансанд' ашигласан (Baillie & Groombridge, 1996). 'Дэлхийн Байгаль Хамгаалах Холбооноос эрхлэн гаргасан Ховор зүйлийн жагсаалтын зэрэглэл болон шалгуур' (IUCN, 2001) нь одоогоор олон улсын стандарт болж хүлээн зөвшөөрөгдсөн төдийгүй дэлхий нийтээрээ энэ шалгуурыг ашиглаж байна.

Монгол орны загасны улаан дансыг Монголын Биологийн олон янз байдлын мэдээллийн сангийн ажлын хэсгийн уулзалтаар 'Ховор зүйлийн шалгууруудыг бүс нутгийн хэмжээнд ашиглах гарын авлагын' (IUCN, 2003) үндсэн шалгууруудыг ашиглан хийж гүйцэтгэсэн. Энэ гарын авлага нь бүс нутгийн хэмжээнд устаж буй зүйлийн үнэлгээг хийсний зэрэгцээ дэлхийн хэмжээнд үнэлгээ нь хийгдсэн тохиолдолд бүс нутгийн хэмжээнд маргаантай асуудал нэг их тохиолдохгүй болохыг тэмдэглэсэн. Жишээлбэл, аль нэг бүс нутгийн үнэлгээ нь улс хооронд нүүдэллэдэг зүйлийг анхааралдаа авах хэрэгтэй, нөгөө талаар аль нэг зүйлийн популяци нэг оронд хязгаарлагдмал боловч бусад орноос нүүдэллэн ирэх популяциас хамааралтай байдаг. Бүс нутгийн хэмжээнд зүйл устаж буй үйл явцын бодит үнэлгээг батлах аргачлал нь үндсэн 2 өвөрмөц онцлогтой. Нэгдүгээрт, энэ нь хоёр шинэ зэрэглэлийг багтааж байдаг. Үүнд: Бүс нутгийн хэмжээнд устсан (RE) болон Үнэлэх боломжгүй (NA) (Хүснэгт 1). Дэлхийн хэмжээнд оршин амьдарч байгаа боловч тодорхой нэг бүс нутагт олдохгүй болсон зүйлийг бүс нутгийн хэмжээнд устсан (RE) гэж тодорхойлдог. Тухайн шалгууруудаар үнэлгээ хийхэд тохирохгүй байгаа зүйлүүдийг Үнэлэх боломжгүй (NA) гэж тодорхойлдог. Монголын Биологийн олон янз байдлын мэдээллийн сангийн ажлын хэсгийн уулзалт дээр нийт популяцийн 1%-д хүрэхгүй хэсэг нь Монголд тохиолдож байгаа бөгөөд бүс нутгийн хэмжээн дэх тархалт нь Монголын нутаг дэвсгэрийн 1%-иас хэтрэхгүй хэсэгт нь тохиолдож буй зүйлүүдийг Үнэлэх боломжгүй (NA) гэж тодорхойлсон.

Хоёрдугаарт, энэ аргачлал нь хоёр алхам бүхий процессыг санал болгодог. 'Дэлхийн Байгаль Хамгаалах Холбооноос эрхлэн гаргасан Ховор зүйлийн жагсаалтын зэрэглэл болон шалгуурыг' (IUCN, 2001) анхлан бүс нутгийн популяцийн мэдээнд хэрэглэж тэрээр дэлхийн нийт популяцид төлөөлүүлэн ашигласан (Хавсралт I эмхтгэлийг нарийвчлан харна уу). Энэ үнэлгээг цааш нь тухайн бүс нутгийн гадна тохиолдох популяцийн нөлөөнд тулгуурлан нийцүүлсэн. Жишээлбэл, хэрэв ямарваа нэгэн зүйл бүс нутгийн хэмжээнд ховордсон боловч тухайн бүс нутгийн гадна орших популяциас шилжин ирэх бодгалиуд тухайн бүс нутгийн популяцид тодорхой байр суурь эзлэж аврал үзүүлэх бөгөөд энэ нь тухайн зүйл уг бүс нутагт устах аюулыг багасгах бөгөөд үнэлгээний асуудал зүй ёсоор дараагийн түвшинд шилжинэ. Хэрэв бүс нутгийн популяци багасах эсхүл тухайн популяци нь дагавар популяци буюу гаднаас аврал ирэх боломжгүй тохиолдолд үнэлгээ ховордлын дээд зэрэглэл рүү өгсөж болох юм. Тус бүс нутгийн эргэн тойрны популяцийн талаарх мэдээлэл байхгүй байгаа тохиолдол тухайн үнэлгээнд ямарч өөрчлөлт хийгдэхгүй (дэлгэрэнгүй мэдээллийг IUCN, 2003 –аас харна уу). Энэ нь тодорхой бүс нутгийн доторх ховордлын зэргийг тусгасан Улаан дансны үнэлгээ бүхий нэр томъёог тодорхойлж өгсөн.

Монголын Биологийн олон янз байдлын мэдээллийн сангийн ажлын хэсгийн уулзалт дээр бүс нутаг дахь загасыг зэрэглэл ахиулах бууруулах үнэлгээг хийгээгүй, учир нь гаднаас шилжин ирэх популяцийн талаарх мэдээлэл, нотолгоо бага байсан бөгөөд гаднах популяциас аврал үзүүлэхүйцээр нөлөөлж буй эсэх нь тодорхойгүй байсан.

Хүснэгт 1. Улаан дансны ангилалын тодорхойлолт (IUCN, 2001 болон 2003).

Устсан (EX)	Хамгийн сүүлчийн бодгаль маргаангүйгээр үхсэн бол тухайн ангилал зүйн нэгжийг ‘Устсан’ гэсэн ангилалаар үнэлдэг. Тухайн зүйлийн бодгаль байж болох амьдрах орчныг тохиромжтой цаг хугацаанд (Өдөр, улирал, жилийн идэвхийг харгалзан) нарийн судалж үзээд мөн тухайн зүйлийн өмнө нь тархаж байсан бүх газар нутгаар судалгаа хийж үзээд нэг ч бодгаль илрүүлээгүй тохиолдолд тухайн зүйлийг ‘Устсан’ гэсэн ангилд оруулна. Судалгааг зүйлийн амьдралын эргэлт ба амьдралын хэлбэртэй уялдсан цаг хугацаанд гүйцэтгэсэн байх ёстой.
Байгалд устсан (EW)	Тухайн зүйлийн бодгалиуд зөвхөн таримал байдлаар, хэрэв зэрлэг амьтан бол тэжээмэл байдлаар үржүүлж байгаа эсвэл тухайн амьтны популяцийг (популяциудыг) урьд нь уугуул тархац нутгийн гадна байгалийн нөхцөлд нь байлгаж байгаа бол ‘Байгальд Устсан’ гэсэн ангилалд оруулдаг. Тухайн зүйлийн бодгаль байж болох амьдрах орчин тохиромжтой цаг хугацаанд (өдөр, улирал, жилийн идэвхийг харгалзан) нарийн судалж үзээд, мөн тухайн зүйлийн уугуул нутагт судалгаа хийж үзээд нэг ч бодгаль илрүүлээгүй тохиолдолд тухайн зүйлийг ‘Байгальд Устсан’ гэсэн ангилд оруулна. Судалгааг зүйлийн амьдралын эргэлт ба амьдралын хэлбэртэй уялдсан цаг хугацаанд гүйцэтгэсэн байх ёстой.
Бүс нутгийн хэмжээнд устсан(RE)	Тухайн зүйлийн хамгийн сүүлийн бодгаль үхсэн эсвэл үзэгдэхээ байсан бөгөөд дахин энэ нутагт шилжин ирэх боломжгүй. Бүс нутгийн хэмжээнд устсан ангилалд энэ зүйлийг оруулахаас өмнө цаг хугацаанд ерөнхий дүрэм тавих боломжгүй. Энэ нь зүйлийн талаарх судалгаа хэр хийгдсэнээс хамаарах болно.
Устаж байгаа (CR)	Тухайн зүйлийн талаарх бүх баримт А -гаас E хүртэлх аль нэг шалгуураар ‘Устаж Байгаа’ (Бүлэг V-г харна уу) гэсэн ангилалаар үнэлэгдэж байгаа бол байгальд устах эрсдэл туйлын их байгааг илтгэдэг тул ‘Устаж Байгаа’ гэсэн ангилалд хамааруулна.
Устаж болзошгүй(EN)	Тухайн зүйлийн талаарх мэдээ баримт А -гаас E хүртэлх шалгуураар шалгахад ‘Устаж Болзошгүй’ (Бүлэг V-г харна уу) гэсэн ангиллаар үнэлэгдсэн зүйл нь байгаль дээр устах эрсдэл их гэж үзэн ‘Устаж Болзошгүй’ гэсэн ангилалд хамааруулна.
Эмзэг (VU)	Тухайн зүйлийн талаарх мэдээ баримт А -гаас E хүртэлх шалгуураар шалгахад ‘Эмзэг’ (Бүлэг V-г харна уу) гэсэн ангилалаар үнэлэгдэж байвал тухайн зүйл байгальд устах эрсдэл их гэж үзэн ‘Эмзэг’ гэсэн ангилалд хамааруулна.
Ховордож болзошгүй (NT)	Тухайн зүйлийг А -гаас E хүртэлх шалгуураар шалгаж үзэхэд Устаж Байгаа, Устаж Болзошгүй, Эмзэг гэсэн ангиллаар үнэлэх боломжгүй боловч ойрын ирээдүйд устаж, ховордож байгааг илтгэсэн дээрх ангиллын аль нэгрүү шилжин орж болзошгүй зүйлийг ‘Ховордож Болзошгүй’ гэсэн ангилалд хамааруулна.
Анхааралд өртөхөөргүй (LC)	Тухайн зүйлийг А -гаас E хүртэлх шалгуураар шалгаж үзэхэд Устаж Байгаа, Устаж Болзошгүй, Эмзэг эсвэл Ховордож Болзошгүй зэрэг ангиллын аль нэгээр үнэлэх боломжгүй байгаа тул ‘Анхааралд өртөхөөргүй’ зүйл гэсэн ангилалд хамааруулна. Өргөн тархац нутаг, элбэг зүйл энэ ангилалд хамаарна.
Мэдээлэл дутмаг(DD)	Тухайн зүйлийн популяцийн төлөв байдал болон тархацыг үндэслэн устах эрсдэлийг тогтоох шууд ба шууд бус үнэлгээ хийхэд мэдээлэл хангалтгүй байгаа нөхцөлд ‘Мэдээлэл Дутмаг’ гэсэн ангилалд хамааруулна. Тухайн зүйлийн элбэгшил, тархацын талаар мэдээлэл дутмаг байж болно. ‘Мэдээлэл Дутмаг’ гэсэн ангилал нь устах, ховордох эрсдлийг илэрхийлсэн ангилал биш юм. Зүйлийг энэ ангилалд оруулах нь тухайн зүйлийн талаар илүү мэдээлэл хэрэгтэй байгааг илэрхийлдэг төдийгүй тухайн зүйлийн талаар ирээдүйд судалгаа хийгдэж, тухайн судалгаа нь тэр зүйлийг устах эрсдэлтэйг нотлох боломжтой байж болно. Байгаа мэдээллийг ашигтайгаар хэрэглэх нь чухал байдаг. Тухайн зүйлийг ‘Мэдээлэл Дутмаг’ мөн Устах эрсдэлтэйг илэрхийлсэн ангиллын алинд нь хамааруулахаа маш анхааралтай шийдэх хэрэгтэй. Хэрэв тухайн зүйлийн тархац нутаг харьцангуй хязгаарлагдмал, тухайн зүйлийг олон жилийн тэртээд судалсан бол тэр зүйлийг ховордох, устах эрдэлтэй ангилалд оруулах нь зайлшгүй зөв зүйтэй шийдвэр юм.
Үнэлэх боломжгүй (NA)	Шалгуураар шалгагдаагүй зүйн нэгж ‘Үнэлэх боломжгүй’ гэсэн ангилалд хамааруулна.

ТЕХНИКИЙН ТЭМДЭГЛЭЛ

Ангилал зүй ба нэршил

Монгол оронд тохиолдох загасны зүйлийн анхны жагсаалтыг М. Kottelat эмхэтгэсэн бөгөөд ажлын хэсгийн цуглааны явцад хянан шинэчилсэн. Үүний дараагаар энэхүү жагсаалтыг ажлын хэсгийн бүх бүлгүүдийн оролцоотойгоор шинэчлэн засварлан хэвлэлд бэлтгэсэн. Мөн түүнчлэн тухайн зүйлийн жагсаалтын ангилал зүйн асуудал болон Монголд тэмдэглэгдсэн зүйлийн тоог хянах судалгааг үргэлжүүлэн гүйцэтгэсэн (Хавсралт II).

Монгол орны загасны улаан дансанд ажлын хэсгийн мэргэжилтнүүд үнэлгээ хийсэн 64 зүйл загасыг багтаасан. ‘Дэлхийн Байгаль Хамгаалах Холбооноос эрхлэн гаргасан Ховор зүйлийн жагсаалтын зэрэглэл болон шалгуур’ (IUCN, 2001)-ыг зөвхөн байгалийн зэрлэг популяциудад ашигласан бөгөөд үүнд Монголд тэмдэглэгдсэн дөрвөн зүйл орсон. Харин зориудаар нутагшуулсан зүйлийг энэхүү улаан данснаас хассан болно. Тухайлбал:

Hypophthalmichthys molitrix (Valenciennes, 1844)

Coregonus peled (Gmelin, 1789)

Coregonus sardinella Valenciennes, 1848

Ctenopharyngodon idella (Valenciennes, 1844)

Ажлын хэсгийн мэргэжилтнүүдээр үнэлгээ нь хийгдэж байсан өөр дөрвөн зүйлийг Монголд тэмдэглэгдсэн гэх хангалттай нотолгоо одоогоор байхгүй гэж үзээд Монгол орны загасны улаан данснаас хассан. Үүнд:

Lethenteron japonicum (Martens, 1866),

Triplophysa stoliczka (Steindachner, 1866)

Triplophysa strauchii Kessler, 1874

Silurus soldatovi Nikolskii and Soin, 1948

Монголд тэмдэглэгдсэн гэж үзсэн гурван зүйлийг ангилал зүйн хувьд дараах байдлаар дахин тодорхойлсон. Үүнд:

Coregonus migratorius (Georgi, 1775) (*C. autumnalis* гэх зүйл биш гэж үзсэн).

Misgurnus mohoity (Dybowski, 1869) (*M. anguillicaudatus* гэх зүйл биш гэж үзсэн)

Sarcocheilichthys soldatovi (Berg, 1914) (*S. nigripinnis* гэх зүйл биш гэж үзсэн)

Дараагийн зүйл болох *Rutilus lacustris* (Pallas, 1814)-ыг *Rutilus rutilus* (Linnaeus, 1758) гэдэг зүйл гэж тайлбар өгсөн.

Эдгээр зүйл тодорхойлох явцад гарсан алдаа болон дахин тайлбар хийсэн тохиолдлууд Монгол орны загасны улаан дансанд засварлагдаж тусгагдсан бөгөөд зүйлийн үнэлгээний асуудалд өөрчлөлт оруулаагүй болно.

Ажлын хэсгийн уулзалтанд хэлэлцэгдсэн дараагийн асуудал нь өөр нэмэлт гурван зүйлийг Монголд тохиолдож байгаа гэж дүгнэсэн (М. Kottelat, хэвлэлийн бэлтгэлд):

Hemiculter varpachovskii Nikolskii, 1903: Буйр нуурт эндемик, Амар мөрний эхээр (Chen Y.-Y., 1998)

Microphysiogobio anudarini Holcнк, Pivnicka, 1969: Буйр нуурын орчимд

Phoxinus ujmonensis Kashenko, 1899: Булган голд

Эдгээр нь ажлын хэсгийн мэргэжилтнүүдээр үнэлэгдээгүй бөгөөд Монгол орны загасны улаан дансанд одоогоор ороогүй байгаа.

Бүс нутгийн тархалт: Монгол орны ус судлал

Зүйл тус бүрийн хувьд бүс нутгийн тархалт нь тэдгээр зүйлүүд тохиолдох гол мөрний ай савууд байх бөгөөд Монгол орны гол, мөрөн, нуурууд нь урсгалынхаа чиглэлээс хамааран гурван том ай савуудад хуваагддаг (Зураг 1). Монгол орны хойд хэсгийн төвөөр урсах голууд Сибирь лүү урсаж Хойд мөсөн далайн ай савын нэг хэсэг болж өгнө. Энэ усны систем нь Сэлэнгэ, Орхон, Туул, Шишхэд гол, мөн Хөвсгөл, Өгий, Тэрхийн цагаан нуурыг өөртөө багтаадаг байна. Монгол орноос зүүн тийш гадагш урсах ус нь Амар мөрний усны системийн эх болох бөгөөд эцэст нь Агнуурын тэнгис болон Номхон далайд хүрнэ. Энэ усны системийг Амар мөрний эсвэл Номхон далайн ай сав хэмээн нэрлэх бөгөөд энэ нь Онон, Хэрлэн голууд, мөн Буйр нуурыг багтаадаг байна. Монгол орны нутаг дэвсгэр дээрх хамгийн том усан сав бүхий бүс нутгийг Төв Азийн гадагш урсгалгүй ай сав бүрдүүлдэг. Энэ нь Баруун болон Төв Азийн ихэнхи хэсгийг хамарсан асар том хаалттай ай сав болно. Баруун Монголд байрлах Их Нууруудын хотгор болон түүнтэй холбоо бүхий голууд, мөн нутгийн өмнөд хэсгээр байрлах Говийн нууруудын хөндий нь энэ ай савын нэг хэсгийг бүрдүүлдэг. Баруун Монголд байрлах Булган гол хэдийгээр Төв Азийн гадагш урсгалгүй, хаалттай ай савд оршдог ч Хойд мөсөн далайн ай савд багтдаг гэж үздэг. Учир нь энэ бүс нутгийн амьтны аймаг Хойд мөсөн далайн ай савд тохиолдох амьтны аймагтай маш их төсөөтэй байдаг. Иймд энэ ай савыг Алтайн уулсын тогтоцоор тусгаарлагдсан Хойд мөсөн далайн ай савын нэг хэсэг гэж үздэг байна.




График 1. Монгол орны ус судлал. Энэ зураг нь Монгол орны усны 3 ай сав болон тэдгээрт хамрагдах гол, нууруудыг харуулж байна.

Зүйлийн газар зүйн зураг

Монгол орон дахь загасны тархалтыг харуулсан тоон системийн газрын зургийг анхны удаа ArcView 3.0 программыг ашиглан дүрсэлсэн. Энэ нь зүйл тус бүрийн тархалтыг тодорхойлох ажлын хэсгийн цуглааны үр дүнд зурагдсан газрын зураг бөгөөд тухайн орны гол, мөрний сав газар болон нуур орчмын судаг, Монгол орны хилээс гадагш сунгасан зарим хэсгийг нийлүүлэн дүрсэлсэн. Тархалтын зургыг хийхдээ зүйлийн баялагын шинж төрхийг илрүүлэх, хорогдож буй зүйлийн баялаг болон тодорхой бус зүйлийн тохиолдоц өндөр байгаа нутаг дэвсгэр зэргийг ArcView 3.0 ашиглан давхар дүрслэх замаар боловсруулсан. Энэ газрын зураг бүх зүйлийн хувьд одоогоор мэдэгдэж буй тархалтыг харуулсан. Гэхдээ өмнө нь Монгол орны загасны судалгаа маш олон чухал ажлуудыг хийж гүйцэтгэсэн боловч тус орны ихэнхи хэсэгт нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай хэвээр үлдсэн учир энэхүү тархалтын зураг бүрэн мэдээллийг агуулсан гэж үзэх нь учир дутагдалтай юм.

ЗҮЙЛИЙН ДАНСНЫ ЗАГВАР

Усны амьтны ангилал зүйн стандартын дагуу дээд түвшний нэршлийг авч ашигласан (Lundberg, 2006) бөгөөд Монгол орны загасны улаан данс нь доор тоймлосон төлөвлөгөөний дагуу хийгдсэн болно:

Зүйлийн нэр болон нэршил зохиогч

Түгээмэл нэр (Англи болон Монголоор)

Ижил нэр/өмнөх хувилбараар/годорхойгүй нэршил (хэрэв ашиглах боломжтой бол)

Дүрслэл

Энд гол төлөв тухайн зүйлийн онцлог шинж чанар болон ангилал зүйн маргаантай асуудлын талаархи товч мэдээллийг тусгасан.

Хамгааллын зэрэг

Дэлхийн хэмжээнд (олон улсад устаж буй эрсдэл)

‘Дэлхийн Байгаль Хамгаалах Холбооноос зарим нэг зүйлийн популяцийн дэлхийн хэмжээний даярхи үнэлгээг’ 2004 онд эмхэтгэн гаргасан ‘Дэлхийн Байгаль Хамгаалах холбооны Улаан дансны ховордож буй зүйл бүтээлд’ тусгасан (IUCN, 2004). Монголын Биологийн олон янз байдалын мэдээлэлийн сангаас зохион байгуулсан мэргэжлийн багуудын уулзалтын үеэр дэлхийн хэмжээнд хийгдсэн зарим үнэлгээнд анхаарал татахуйц өөрчлөлт орж буйг онцлон нэг дугариг хараар (•) тэмдэглэсэн. Тухайн зүйл болоод салбар зүйлийн хувьд анхны үнэлгээ нь хийгдэж байгаа тохиолдолд ‘Дэлхийн Байгаль Хамгаалах Холбооноос эрхлэн гаргасан ховор зүйлийн жагсаалтын зэрэглэл болон шалгуур’ (IUCN, 2001)-ыг ашигласан бөгөөд Дэлхийн Байгаль Хамгаалах Холбооны мэргэжилтнүүдийн үнэлгээ зайлшгүй хэрэгцээтэй байгаа ховор зүйлүүдийг тусгайлан хоёр дугариг хараар (••) тэмдэгээр илэрхийлсэн.

Бүс нутагт (Монголд устах эрсдэлтэй зүйлүүд)

‘Дэлхийн Байгаль Хамгаалах Холбооноос эрхлэн гаргасан Ховор зүйлийн жагсаалтын зэрэглэл болон шалгуурын 3.1 хувилбар’ (IUCN, 2001) болон ‘Ховор зүйлийн шалгууруудыг бүс нутгийн хэмжээнд ашиглах гарын авлага: 3.0 хувилбар’ (IUCN, 2003)-ыг ашиглан боловсруулсан Монгол орны загасны үнэлгээ нь бүс нутгийн хэмжээнд анх удаагаа хийгдэж байгаа юм. Хэрэв зүйл нь Монгол орны эндемик бол дэлхийн хэмжээнийхтэй адилтган үзнэ.

Үнэлгээний бодит байдал

‘Дэлхийн Байгаль Хамгаалах Холбооноос эрхлэн гаргасан Ховор зүйлийн жагсаалтын зэрэглэл болон шалгуурыг’ (IUCN, 2001) бүх зүйлд хэрэглэхдээ Монголын Биологийн олон янз байдлын хэсгийн уулзалт дээр харилцан шүүн хэлэлцэж бодит байдалд нийцүүлсэн болно. Энэ бүлгийг Монголын Биологийн төрөл зүйлийн мэдээллийн сан болон ‘IUCN-н Улаан жагсаалтын бүс нутгийн шалгуурын гарын авлагыг Хувилбар 3.0’-тэй холбож унших хэрэгтэй (IUCN, 2003).

Хууль цаазанд (Хэрэв ашиглах боломжтой бол)

Монголын загасны зүйл, түүнийг хамгаалах зорилго бүхий Монгол улсын хуулиуд, (Ан агнуурын тухай хууль, Амьтны тухай хууль) болон Олон улсын хуулиуд (ө.х. Зэрлэг амьтан ургамлын ховордсон төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци (UNEP-WCMS, 2006)) байдаг. Монголын орны загасны бүх зүйлүүдийн агналт хийх хугацааг тусгайлан хуулиар тодорхойлсон байдаг. Тухайлбал, Буйр нуурт 5 сарын 15 наас 6 сарын 1 ний хооронд, загас агнах хориотой байдаг төдийгүй бусад бүх зүйлийн загас / загасны популяцийг 4 сарын 1 нээс 6 сарын 16 ны хооронд агнахыг хуулиар хориглосон байдаг. Ан агнуурын тухай хуулиар агнахыг хориглосон эсхүл Амьтны тухай хуулинд ховор болон маш ховор амьтны жагсаалтад бичигдсэн зарим зүйлийн агналт хийх хугацаанд хязгаарлалт хийсний зэрэгцээ агналтанд агнахыг нь урт удаан хугацаагаар хориглосон (Wingard & Odgerel, 2001).

Тархац

Дэлхийн тархац

Зүйл тус бүрийн хувьд дэлхий даярх тархалтыг Kottelat (хэвлэлтэн байгаа), Reshetnikov нар (1997) болон Reshetnikov (2001)-ын бүтээлд тулгуурлан тодорхойлсон болно.

Бүс нутагт

Монгол орны зүйлийн тархалтын зургийг мөрдлөгө болгосон. Зүйл тус бүрийн бүс нутаг дахь тархалтыг тодорхойлохдоо зориудаар нутагшуулсан бүс нутаг болон бусад улс оронд зориудаар нутагшуулсаны улмаас тухайн нутагт хөнөөл учруулах болсон зэрэг нутгийг оруулалгүйгээр зөвхөн байгалийн тархалтыг, тухайлбал гол, горхи, нуур цөөрөм, болон тэдгээрийн ширгэж хуурайшсан сайр зэргийг тэмдэглэн оруулсан. Түүнчлэн өнөөг хүртэл ихэнхи зүйлүүдийн тархалтын талаархи мэдээлэл нь өнөөг хүртэл хомс байсангаа тул цаашид судалгаа шинжилгээг нарийвчлан хийх шаардлагтайг тэмдэглэх нь зүйтэй. Иймд уг эмхэтгэлд дүрслэгдсэн тархалтын зурагт өөрчлөлт орох боломжтой юм. Монгол орны нутаг дэвсгэрийн гаднах тархалтын зурагт шинэчлэлт хийгдээгүй болно.

Хорогдлын шалтгаан

Монголын Биологийн олон янз байдлын мэдээлэлийн сангаас зохион байгуулсан ажлын хэсгийн уулзалтын үеэр зүйл хорогдох үйл явцад урьд өмнө нь болоод ойрын үед тулгарч байгаа асуудлуудыг тодруулсны зэрэгцээ бусад ном, эх сурвалжуудыг ашиглан хорогдлын шалтгааны гол үндэслэлийг тодорхойлсон болно. Аливаа нэг зүйл устах үйл явц нь бүхэл бүтэн цогц асуудал байж болох талтай бөгөөд маш олон хүчин зүйлээс хамааралтай байдаг. Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Монголын Биологийн төрөл зүйлийн мэдээллийн сангаас авна уу.

МОНГОЛ ОРНЫ ЗАГАСНЫ ЗЭРЭГЛЭЛ

Монгол орны загасны 64 уугуул зүйлээс 48 нь ‘Дэлхийн Байгаль Хамгаалах Холбооноос эрхлэн гаргасан Ховор зүйлийн жагсаалтын зэрэглэл болон шалгуур’ (IUCN, 2001)- ыг хэрэглэх аргачлалын дагуу бүс нутгийн түвшинд хамгааллын зэрэглэлд ангилагдсан. Бусад 16 зүйл нь Үнэлэх боломжгүй (NA) гэсэн ангилалд орсон. Монгол орны загасны зүйлийн дөрөвний нэг нь анхааралд өртөөгүй хэмээн тодорхойлогдсон байхад үлдсэн хэсгийн 23% - д нь Монголд устах аюул нүүрлээд байгаа бөгөөд хорогдож байгаа (Устаж байгаа, Устаж болзошгүй болон Эмзэг гэсэн зэрэглэлд) гэж үзсэн. Үүнээс гадна 6% нь цаашид ховордлын аль нэг зэрэгт ороход бэлэн байгаа бөгөөд Ховордож болзошгүй (NT) гэсэн жагсаалтанд орсон (График 2).




График 2. Монгол орны загасны 48 уугуул зүйлд Дэлхийн Байгаль Хамгаалах Холбооноос эрхлэн гаргасан Ховор зүйлийн жагсаалтын зэрэглэл болон шалгуурын дагуу хийгдсэн хамгааллын зэрэглэлийн үнэлгээ. CR = Устаж байгаа, EN = Устаж болзошгүй, VU = Эмзэг, NT = Ховордож болзошгүй, LC = Анхааралд өртөөгүй, DD = Мэдээлэл дутмаг.

Хүмүүсийн дунд сайн танигдах болсон зүйлүүд, тухайлбал агнуурын болон спорт агнуурын загас, тэдгээрийн популяцийн хандлагыг тухайн загасны баригдалт буурснаар тодорхойлж, дүгнэлт гаргаж болох юм. Харин түгээмэл ашиглагдахгүй зүйлийн хувьд тоо толгойн бууралтыг устаж байгаа үйл явц нь тодорхой баримтаар нотлогдсон үед дүгнэлт хийж болно. Зүйлийн биологийн асуудал болон үнэлгээ нь хийгдсэн хэдий ч популяцийн хэмжээ, цаашдын хандлага нь тодорхойгүй, (46%) тэдгээрийг устах аюулд хүргэж буй хүчин зүйлийн нөлөөний талаарх хангалттай мэдээ байхгүй зүйлүүдийг Мэдээлэл дутмаг (DD) гэсэн ангилалд оруулсан (График 2). Эдгээр загаснуудын ихэнхи нь маш жижиг тул эдийн засгийн ач холбогдол багатай бөгөөд спорт агнуурынхан ч сонирхдоггүй. Монголд зөвхөн Шивэр хилэм (*Acipenser baerii*) ганцаараа ‘Устаж байгаа’ гэсэн ангилалд орсон (Хүснэгт 2). Монголын хилэмийн төрлийн бусад загаснаас Амар мөрний хилэм (*A. schrenkii*) Монголд тохиолддог эсэх нь тодорхойгүй байгаа гэсэн

шалтгаанаар ‘Мэдээлэл дутмаг’ (DD) гэсэн ангилалд орсон. Хэрэв энэ зүйл Монголд тэмдэглэгдсэн, одоо ч тохиолдож байгаа гэж үзэх юм бол энэ зүйл ‘Устаж байгаа’ гэсэн ангилалд орох болно. Зургаан зүйлийг ‘Устаж болзошгүй’ (EN) гэж үзэн энэ ангилалд оруулсан. Эдгээрт Амар мөрний хадран (*Thymallus grubei*), Хөвсгөл хадран (*T. nigrescens*), Тул (*Hucho taimen*) болон Цагаан загас (*Coregonus pidschian*) гэсэн дөрвөн зүйл загас орох бөгөөд эдгээрийг агнуурын болон алжаалаа тайлах зорилгоор барьдаг. Үлдсэн 2 зүйл болох Зүүн гарын сугас (*Leuciscus dzungaricus*) болон Говийн эрээлж (*Barbatula dgebuadzei*) загас нь одоогийн байдлаар зөвхөн нэг газарт тохиолддог бөгөөд алтны уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эрсдэлтэй зүйл хэмээн тодорхойлогдсон. Дөрвөн зүйл загас нь ‘Эмзэг’ гэсэн зэрэглэлд орсон.

Хүснэгт 2. Загасны зүйлийг бүс нутгийн хэмжээнд ховордлоор нь ангилсан байдал (Устаж байгаа, Устаж болзошгүй, Эмзэг болон Монголд ховордож болзошгүй)

Устаж байгаа	Устаж болзошгүй	Эмзэг	Ховордож болзошгүй
Шивэр хилэм <i>Acipenser baerii</i>	Говийн эрээлж <i>Barbatula dgebuadzei</i>	Нохой сугас <i>Oreoleuciscus angusticephalus</i>	Хатгуурт халбаган загас <i>Acheilognathus asmussi</i>
	Зүүн гарын сугас <i>Leuciscus dzungaricus</i>	Давжаа сугас <i>Oreoleuciscus humilis</i>	Бух сугас <i>Leuciscus idus</i>
	Цагаан загас <i>Coregonus pidschian</i>	Монгол хадран <i>Thymallus brevirostris</i>	Шивэр хадран <i>Thymallus arcticus</i>
	Амар мөрний хадран <i>Thymallus grubei</i>	Зэвэг <i>Brachymystax lenok</i>	
	Хөвсгөл хадран <i>Thymallus nigrescens</i>		
	Тул <i>Hucho taimen</i>		

МОНГОЛ ОРНЫ ЗАГАСНЫ ТАРХАЛТ

Монголын загасны зүйлийн баялгийг дөрвөн бүсэд тоймлон хувааж болох юм (График 3). Зүүн хойд бүсэд Амар мөрний сав газар багтах бөгөөд 31 гаруй зүйл тохиолдох Онон голын сав болон Буйр нуур нь зүйлийн баялаг хамгийн ихтэйд тооцогддог. Монголын хойд нутгийн төв хэсэг Хойд мөсөн далайн ай савд багтдаг. Энэ бүс нь загасны зүйлийн баялагаараа Амар мөрний ай савын дараа ордог байна. Монголын баруун хойд бүс болон Говийн хөндийн нуурууд нь Төв Азийн гадагш урсгалгүй ай савд хамаарагдах бөгөөд загасны зүйлийн баялгаар хамгийн багатайд тооцогддог. Гэхдээ энэ бүс нь Монголын ихэнх ховордож буй загасыг, тухайлбал, Монгол хадран (*Thymallus brevirostris*), Нохой сугас (*Oreoleuciscus angusticephalus*), Зүүн гарын сугас (*Leuciscus dzungaricus*) болон Говийн эрээлж (*Barbatula dgebuadzei*) зэргийг агуулж байдаг.

Монгол орны хойд хэсгийн бараг тал орчим хувьд нь ховордож байгаа загасны зүйлийн газарзүйн тархалтанд ямар нэгэн тодорхой хандлага илрээгүй (График 4).




График 3. Монголын загасны зүйлийн баялаг. Гүн өнгөөр будагдсан хэсгүүдэд ховордож буй зүйлүүдийн ихэнх нь тохиолдож байгаа нь харагдаж байна.




График 4. Монгол оронд ховордож буй загасны зүйлийн баялаг. Гүн өнгөөр будагдсан хэсгүүдэд ихэнх ховордож буй зүйлүүд тохиолдож байна.

Монголд загасны зүйлийн баялаг хамгийн их байгаа бүс нь Мэдээлэл дутмаг зүйлийн тоо ихтэй нутгуудтай илүү хамааралтай байдаг. Тухайлбал, Онон гол орчимд зүйлийн баялаг хамгийн их байдаг ч энэ бүсэд Мэдээлэл дутмаг (DD) гэсэн ангилалд орсон зүйлүүд хамгийн ихээр тархаж байна (График 5).




График 5. ‘Мэдээлэл дутмаг’ хэмээн тодорхойлогдсон зүйлийн баялаг. Гүн өнгөөр будагдсан хэсгүүдэд ихэнхи Мэдээлэл дутмаг зүйлүүд тохиолддог болохыг үзүүлсэн.

МОНГОЛ ОРНЫ ЗАГАСНЫ ХОРОГДОЛ

Үнэлгээний үйл явц зүйлийн хорогдлыг удирдан чиглүүлж буй гол үйл ажиллагааг тодорхойлоход оршиж байсан.

Монгол орны загасыг үхэл хорогдолд хүргэж буй бодит аюул нь загас агнуур юм. Ихэнхи хорогдож буй гэсэн зүйлийн зургаа нь энэхүү үйл ажиллагаанд өртжээ. (Хүснэгт 3). Хууль бусаар загасчлах, мөн ямар ч зохицуулагагүй загас агнуур хийх явдал их байгаа нь загасыг үхэл хорогдолд хүргэх гол шалтгаан болж байгаа бөгөөд энэ асуудал өнөөг хүртэл Монголд оршсоор байна. Загас агнуур нь Олон улсын худалдааны өсөн нэмэгдэж буй түвшинээр зохицуулагдаж байдаг. Загас агнуурт зохицуулга байхгүй болсон бөгөөд агнуурын нөөц хангалтгүй, хулгайн агнуур нь тодорхой нэг зүйлийг онцолдоггүй гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Орон нутгийн хэрэглээ нь зүйлийг эрсдэлд хүргэж буй агнуурын зөвхөн өчүүхэн хувийг эзэлж байхад ихэнх хувь нь гадаадын ихэвчлэн Хятад болон Оросын зах зээлд худалдаалагддаг.

Амьдрах орчны доройтол нь ховордож буй зүйл загасны нэн түрүүнд нүүрлэх аюул, гамшигт тооцогддог байхад бусад бүх зүйл загасны тал хувиас илүүд нь нүүрлэж буй гамшгийн хоёрдугаарт орж байна. Ихэнхи тохиолдолд, эдийн засгийн хувьд ач холбогдол бүхий төвлөрсөн газруудад, ялангуяа алтны уул уурхайн олборлолтын үйл ажиллагааны дүнд амьдрах орчин доройтдог. Уурхайн олборлолтын явцад голд тундасжилт нэмэгдснээр тухайн орчинд амьдарч байсан зүйл хоол тэжээлээр дутагдах, өндөгний хөгжил удааширч, амьдрах орчны хомсдолд ордог байна. Мөнгөн ус, цианид ашиглан алт ялгах хүнд хэлбэрийн уурхайн үйл ажиллагааны явцад гол, мөрөнд органик бус бохирдлын аюул нүүрлэдэг. Иймээс алт олборлолтын үйл ажиллагаа нь гол мөрөнд учирч болох аюул заналыг тодорхойлдог байна. Энэхүү нөөцийн төвлөрөлтэй холбоотой бохирдол эсвэл боловсруулалт хийлгүй хаясан хог хаягдал нь цаашид гарах болох гуравдагч аюул болоод байна.

Буйр, Хөвсгөл болон Говийн нууруудын усны түвшин багассанаас амьтадын амьдрах орчин хомсдон доройтох аюул нүүрлэж байна. Буйр нуурын усны түвшин буурсан явдал нь өвлийн улиралд загас агнуурын ажил эрхлэхтэй холбоотойгоор нуур орчмын бургасыг багасгах, хүний нөлөө хэт их гэж үзэж байгаа (Г. Баасанжав, аман мэдээ).

Уур амьсгалын өөрчлөлт нь ихэнхи ховордож буй зүйлийн, хоёрт нь нэн түрүүнд нүүрлэж буй аюул, гамшигт тооцогдсон бөгөөд Монгол орны цэвэр усны системд нутагших зүйлд гамшиг учруулах хүчин зүйлд зүй ёсоор орно. Усны түвшин багассанаас болж амьдрах орчны хомсдол бий болох үйл явц нь цаашид Монгол орны бүх нутагт тархах зүйл, ялангуяа говийн бүсэд нилээд сөрөг үр дагавар учруулж болох талтай. Уур амьсгалын өөрчлөлтөөс болж аль нэг зүйлийн амьдрах орчны тааламжтай байдалд өөрчлөлт орж байгаа талаарх мэдээлэл аль ч бүс нутагт тэмдэглэгдээгүйн учир нь ихэнхи зүйлүүд таньж мэдэгдэхээсээ өмнө устаж алга болж байгаа байх гэсэн санааг илэрхийлж байж болох юм.

Цагаан загас (*Coregonus pidschian*)-ны хувьд гол нүүрлэж буй аюул бол зориудаар үхэл, хорогдолд хүргэх буюу агнаж устгах үйл ажиллагаа юм. Амьдрах орчны доройтол бол түүнийг хорогдолд хүргэж буй гол аюул биш юм. Харин энэ зүйлийн хувьд гаднаас нутагшуулсан бух зарам (*C. peled*) загастай эрлийзжиж байгаа болон түүнтэй өрсөлдөөнд орж байгаа явдал нь уг загасанд нүүрлэх бас нэг аюул болж болох талтай.

Монголын загасанд нүүрлэж буй аюул өсөн нэмэгдсээр байгаа бөгөөд нөлөөлөл нь илүү ноцтой болж байна. Хууль бус агналт нь ихэнхи зүйлүүдэд шууд сөрөг нөлөө үзүүлэх бөгөөд бараг бүх зүйлүүдэд ноцтой аюул учруулсаар байна. Нөөцийн хэмжээ бол шууд нөлөөлөх хүчин зүйл бус төдийгүй сөрөг нөлөө багатай. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн гамшигтай хоршсон тохиолдолд Монгол орны загасны амьдрах чадварт нэлээд хүндрэл учруулах боломжтой.

Хүснэгт 3. Монголын ховордож буй загасанд нүүрлэж буй аюул. Монголын Биологийн олон янз байдлын мэдээллийн сангийн ажлын хэсгийн уулзалтанд оролцогсдын тодорхойлсноор тусгав. Нэн түүрүүнд нүүрлэж буй аюулыг хар дөрвөлжингөөр, хоёрдугаарт нүүрлэж буй аюулын хар саарлаар, гуравдагч аюулыг цайвар саарлаар дүрслэн үзүүлэв.

Ховордлын зэрэглэл	Зүйл	Амьдрах орчны доройтол	Амьдрах орчны хомсдол	Бохирдол	Эрлийзжилт	Өрсөлдөгч	Зориудаар үхэл хорогдолд хүргэх	Цаг уурын өөрчлөлт
CR	<i>Acipenser baerii</i>							
EN	<i>Barbatula dgebuadzei</i>							
	<i>Leuciscus dzungaricus</i>							
	<i>Coregonus pidschian</i>							
	<i>Thymallus grubei</i>							
	<i>Thymallus nigrescens</i>							
	<i>Hucho taimen</i>							
VU	<i>Oreoleuciscus angusticephalus</i>							
	<i>Oreoleuciscus humilis</i>							
	<i>Thymallus brevirostris</i>							
	<i>Brachymystax lenok</i>							

ЗҮЙЛИЙН ЖАГСААЛТ

БАГ ДУГАРИГ АМТАН

Овог: Хорхой загасныхан

1. *Lethenteron reissneri* (Dybowski, 1869)

Түгээмэл нэр: Eastern brook lamprey (Англи),
Хорхой загас, могор (Монгол)

Ижил нэр: *Lampetra reissneri*, *Petromyzon reissneri*

Бүс нутагт: Үнэлэх боломжгүй

Үнэлгээний бодит байдал: Дэлхийн популяцийн 1% хүрэхгүй хэсэг нь Монголд тохиолдох бөгөөд бүс нутгийн тархалт Монгол орны нутаг дэвсгэрийн 1% -иас бага хэсгийг эзэлдэг.

Дэлхийн тархац: Сибирийн далай тэнгистэй нийлсэн хэсгийн эрэг орчмоор, Берингийн тэнгисээс салаалсан гол горхи, Агнуурын тэнгис (Орос), Амар мөрний сав (Хятад, Монгол) доошлоод Солонгос, Япон руу.

Бүс нутагт: Онон голын (Амар мөрний) ай сав. Эдгээр нутаг дэвсгэрийн хүрээнд зүйлийн тархалт тодорхой бус байсан тул тархалтын газрын зургийг дүрслэх хүндрэлтэй байв.


Хорогдлын шалтгаан: Тодорхойгүй.

БАГ ХИЛЭМТЭН

Овог: Хилэмийнхэн

2. *Acipenser baerii* Brandt, 1869

Түгээмэл нэр: Siberian sturgeon (English),
Шивэр хилэм (Монгол)



Дэлхийн хэмжээнд: Эмзэг, A2d (Sturgeon Specialist Group, 1996)
Дор дурьдсан салбар зүйлүүдийн үнэлгээг (Sturgeon Specialist Group, 1996)
авч үзвэл:

Acipenser baerii baerii Устаж болзошгүй, A2d

Acipenser baerii baikalensis Устаж болзошгүй, A1ace

Acipenser baerii stenorrhynchus Эмзэг, A2d

Салбар зүйлүүдийн ангилал зүй, нэршлийн талаарх асуудлыг хянаж үзэх шаардлагатай (M. Kottelat, аман мэдээ.).

Бүс нутагт: Устаж байгаа, B2ab (iii,v)

Үнэлгээний бодит байдал: Тохиолдох нутаг дэвсгэрийн хэмжээ 10 км²-аас бага. Түрсээ шахах 3 газар (2 нь Сэлэнгэд, 1 нь Орхонд) байдаг. Энэ нь зөвхөн нэг орчинд байрлах ба энэ орчимд хууль бус агналт хийх явдал (B шалгуурт үндэслэсэн) нь уг загас хорогдох үндсэн шалтгаан нь болдог байна. Алт олборлолтын үйл ажиллагааны явцад үүсэх тундасжилт, бохирдлоос үүдэн амьдрах орчны тааламжтай байдал алдагдах, мөн ихэнх үржлийн насны бодгалийг хулгайгаар агнах болсонтой уялдаж зүйлийн тоо толгой багассаар байна. Бүс нутгийн шалгуурыг хэрэглэсний дараа хамгааллын зэрэглэлд өөрчлөлт ороогүй. Учир нь Оросоос нүүдэллэн ирэх популяци буурсан ч тус бүс нутгийн популяци нь 'дагавар' популяци биш юм гэж тодорхойлсон.

Хууль цаазанд: Монголын Ан амьтны тухай хуулинд маш ховор гэсэн ангилалд бүртгэгдсэн. Ан агнуурын тухай хуулинд маш ховор зүйл загасыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнахыг хориглосон. Ховор зүйл худалдаалах олон улсын конвенцийн (II хавсралт) болон Нүүдлийн зүйл хамгаалах конвенцийн II хавсралтанд орсон.

Дэлхийн тархац: Обь мөрнөөс Колым хүртэлх голууд, Енисей мөрөн, Зайсан, Байгаль нуурт тархсан. Уг зүйл тархсан нутаг дэвсгэрийн өмнөд хил нь Монголын Сэлэнгэ мөрөн, Иртыш гол, Казакстан болно.

Бүс нутагт: Сэлэнгэ, Орхон гол, Хараа голын адаг (Хойд мөсөн далайн ай сав).

Хорогдлын шалтгаан: Худалдааны зорилгоор хууль бусаар агнах; Хот суурин газрын бохирдол болон том, жижиг алтны уурхайн Үйл ажиллагааны явцад бий болсон органик бус бохирдлын улмаас амьдрах орчин нь доройтолд орсон; Алт олборлох үйл ажиллагааны явцад бий болж буй сөрөг нөлөөгөөр, тухайлбал, голын хэлбэр төрхийг өөрчилж, ёроолд нь лаг шавар их хэмжээгээр хуримтлагдах зэргээс болж загас амьдрах орчин доройтолд орох юмуу эсвэл амьдрах орчны хомсдолд орсон.

3. *Acipenser schrenkii* Brandt, 1869

Түгээмэл нэр: Amur sturgeon (Англи),
Амарын хилэм (Монгол)

Дэлхийн хэмжээнд: Устаж болзошгүй, A1acd болон A2d

Бүс нутагт: Мэдээлэл дутмаг

Үнэлгээний бодит байдал: Тархалт, популяцийн хэмжээ болон хандлагын талаарх мэдээлэл хангалтгүй, хорогдолд хүргэж буй шалтгаан тодорхойгүй. Энэ зүйл нь 1976 оноос хойш Монголд тэмдэглэгдээгүй (М.Эрдэнэбат, аман мэдээ). Сүүлийн үед сайн судалгаа хийгдээгүй учраас үүнийг бүс нутгийн хэмжээнд 'Устсан' гэж дүгнэлт хийж болохгүй.

Хууль цаазанд: Монголын Ан амьтны тухай хуулинд маш ховор гэсэн ангилалд бүртгэгдсэн. Ан агнуурын тухай хуулинд маш ховор зүйл загасыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнахыг хориглосон. Ховор зүйл худалдаалах олон улсын конвенцийн (II хавсралт) болон Нүүдлийн зүйл хамгаалах конвенцийн (II хавсралтан) орсон.

Дэлхийн тархац: Амар мөрний сав газар (Хятад, Орос, Монголд).

Бүс нутагт: Тодорхойгүй. Тухайн зүйлийн тархалт тодорхой бус байсан тул тархалтын газрын зургийг дүрслээгүй болно.


Хорогдлын шалтгаан: Тодорхойгүй.

БАГ МӨРӨГТӨН

Овог: Эрээлжийнхэн

4. *Barbatula dgebuadzei* (Prokofiev, 2003)

Түгээмэл нэр: Gobi loach (Англи),
Говийн эрээлж (Монгол)



Бүс нутагт: Устаж болзошгүй, B2ab (iii)••

Үнэлгээний бодит байдал: Энэ зүйл Заг (Бөөн Цагаан нуурын сав газарт багтдаг гэж үзэх) горхинд зөвхөн нэг удаа эргэлзээгүй тохиолдсон. Түүнчлэн энэ зүйлийн өөр нэг дээжийг Орог нуураас барьсан. Тархац нутгийн хэмжээ ойролцоогоор 400 км² (уг горхины урт 200 км × 5 м өргөн, дунджаар) (В шалгуур) гэж тооцоолсон. Энэ зүйл тэмдэглэгдсэн ганцхан нутаг болох энэхүү горхи нь алт олборлолтын үйл ажиллагааны нөлөөлөлд орж амьдрах орчин нь хэмжээний хувьд улам багассаар байна.


Дэлхийн тархац: Монгол.

Бүс нутагт: Заг горхи болон Заг сумын ойролцоох Байдраг голын сав газар (Төв Азийн гадагш урсгалгүй ай сав).

Хорогдлын шалтгаан: Алт олборлолтоос үүдэлтэй амьдрах орчны доройтол.

5. *Barbatula toni* (Dybowski, 1869)

Түгээмэл нэр: Siberian stone loach (Англи)
Сахалт эрээлж (Монгол)



Бүс нутагт: Анхааралд өртөөгүй.

Үнэлгээний бодит байдал: Маш өргөн тархалттай том популяци байдаг хэдий ч хорогдлын шалтгаан тодорхойгүй.


Дэлхийн тархац: Уралын зүүн хэсгээр, Казакстан, Монгол, Хятадын Хойд хэсэг, Солонгос, Япон.

Бүс нутагт: Онон, Хэрлэн, Халхын голууд Буйр Нуур (Амарын савд), Сэлэнгэ мөрний савд, Шишхэд гол (Хойд мөсөн далайн ай сав). Энэ зүйлийн Говьд тэмдэглэсэн дээжийг хянаж үзээд *Barbatula dgebuadzei* зүйл болохыг тэмдэглэсэн. Ховдоос тэмдэглэгдсэн зүйл нь өөр зүйлтэй андуурагдсан гэж дүгнэсэн (Kottelat, хэвлэлтэнд буй).

Хорогдлын шалтгаан: Алтны уурхайн үйл ажиллагааны улмаас амьдрах орчин нь чанарын хувьд доройтолд орсон. Мөн хотын ойролцоох хог хаягдлаас гол бохирдож хүчилтөрөгчийн хангамж буурах болсон.

6. *Lefua costata* Kessler, 1876

Түгээмэл нэр: Lefua (Англи),
Наймас эрээлж (Монгол)



Бүс нутагт: Үнэлэх боломжгүй

Үнэлгээний бодит байдал: Дэлхийн популяцийн 1% хүрэхгүй хэсэг нь Монголд тохиолдох бөгөөд бүс нутгийн тархалт Монгол орны нутаг дэвсгэрийн 1% -иас бага хэсгийг эзэлдэг.


Дэлхийн тархац: Амарын мөрний ай савд (Хятад, Орос, Монгол).

Бүс нутагт: Азаргын гол, Тамсагын булаг болон Буйр нуурын савд багтах бусад голууд (Амар мөрний сав).

Хорогдлын шалтгаан: Тодорхойгүй.

7. *Triplophysa gundriseri* Prokofiev, 2002

Түгээмэл нэр: Tes Gol loach (Англи),
Тэсийн эрээлж (Монгол)



Бүс нутагт: Мэдээлэл дутмаг

Үнэлгээний бодит байдал: Тархалт, популяцийн хэмжээ болон хандлагын талаарх мэдээлэл хангалтгүй, хорогдолд хүргэж буй шалтгаан тодорхойгүй.

Дэлхийн тархац: Монгол.

Бүс нутагт: Тэс гол болон Сангийн далай нуур (Төв Азийн гадагш урсгалгүй ай сав).

Хорогдлын шалтгаан Тодорхойгүй.

Санал: Урьд өмнө нь *Triplophysa strauchii* гэж тодорхойлж байсан зүйлийг *Triplophysa gundriseri* (Prokofiev, 2002) гэж засаж өөрчилсөн.


Овог: Яралжийнхан

8. *Cobitis melanoleuca* Nichols, 1925

Түгээмэл нэр: Siberian spiny loach (Англи),

Шивэр чимхүүр загас (Монгол)

Ижил нэр: *Cobitis taenia granoei*, *Cobitis taenia sibirica*



Бүс нутагт: Анхааралд өртөхөөргүй.

Үнэлгээний бодит байдал: Маш өргөн тархалттай том популяци тэмдэглэгдсэн. Популяцийн тоо толгойн бууралт ажиглагдаагүй.

Дэлхийн тархац: Оросын Волга мөрний сав газраас Амар мөрөн хүртэл, Хуанг Не мөрний сав газар (Хятад, Орос, Монгол, Казакстан).

Бүс нутагт: Онон, Хэрлэн голын сав (Амар мөрний сав), Сэлэнгэ мөрний сав (Хойд мөсөн далайн ай сав), Булган голын сав.


Хорогдлын шалтгаан: Алт олборлолтын үйл ажиллагаанд хэрэглэсэн хүнд металлын болон тундасжилтын улмаас амьдрах орчин нь доройтолд орсон.

9. *Misgurnus mohoity* (Dybowski, 1869)

Түгээмэл нэр: Amur weather loach (Англи),

Амарын моголзой (Монгол)

Тодорхойгүй нэршил: *Misgurnus anguillicaudatus*



Бүс нутагт: Анхааралд өртөхөөргүй.

Үнэлгээний бодит байдал: Маш өргөн тархалттай том популяци тэмдэглэгдсэн. Популяцийн тоо толгойн бууралт ажиглагдаагүй.

Дэлхийн тархац: Амарын савд (Хятад, Орос, Монгол) болон Хятадын зүүн хойд хэсэгт


Бүс нутагт: Онон, Хэрлэн, Улз, Халхын гол болон Буйр нуур (Амар мөрний савд).

Хорогдлын шалтгаан: Алт олборлолтын үйл ажиллагаанд хэрэглэсэн хүнд металлын улмаас амьдрах орчин нь доройтолд орсон.

Овог. Мөрөгийнхөн

10. *Acheilognathus asmussi* (Dybowski, 1872)

Түгээмэл нэр: Amur spiny bitterling (Англи),
Хатгуурт халбаган загас (Монгол)



Бүс нутагт: Ховордож болзошгүй

Үнэлгээний бодит байдал: Энэ зүйл тохиолдох нутаг дэвсгэрийн хэмжээ 2000 км² талбайгаас бага байгаа учраас В2 шалгуурт их дөхөж очсон. Гэхдээ В шалгуурын бусад ангилал тохирохгүй байгаа. Хатгуурт халбаган загас махлаг зүйл тул Хятадад хэрэгцээ нь улам нэмэгдэж байгаагаас ирээдүйд ховордох магадлалтай. Бүс нутгийн шалгуурыг хэрэглэсний дараа хамгааллын зэрэглэлд өөрчлөлт ороогүй. Хятадаас нүүдэллэн ирэх популяци нэг их биш ч тус бүс нутгийн популяци нь 'дагавар' популяци биш юм гэж тодорхойлсон.


Дэлхийн тархац: Амарын савд (Хятад, Орос, Монгол, Солонгос).

Бүс нутагт: Онон, Хэрлэн голууд, Буйр нуур (Амар мөрний сав газар).

Хорогдлын шалтгаан: Хатгуурт халбаган загас авгалдай үедээ цэнгэг усны дунгийн хавтсанд амьдрах бөгөөд амьдрах орчны доройтлын улмаас тухайн дунгийн зүйл ховордсон нь уг зүйл загас хорогдох үндсэн нөхцлийг бүрдүүлж өгсөн. Мөн Буйр нуурын гүнд тор татаж загас агнуурын ажил эрхлэх болсон нь уг загасны тоо толгой буурахад хүргэсэн. Хятадад худалдааны хэрэгцээ нэмэгдэхэд хууль бус агналт ихсэж тухайн зүйлд тулгарах аюул нэмэгддэг байна.

11. *Carassius carassius* (Linnaeus, 1758)

Түгээмэл нэр: Crucian carp (Англи),
Алтлаг хэлтэг (Монгол)



Бүс нутагт: Үнэлэх боломжгүй

Үнэлгээний бодит байдал: Дэлхийн популяцийн 1% хүрэхгүй хэсэг нь Монголд тохиолдох бөгөөд бүс нутгийн тархалт Монгол орны нутаг дэвсгэрийн 1% -иас бага хэсгийг эзэлдэг.


Дэлхийн тархац: Европ, Рине мөрний сав газрын баруун бие, Герман, Лена мөрний зүүн бие, Орос, Балтын Хойд, Баренцов, Хар болон Каспийн тэнгисийн сав газар. Итали, Англи, Франц, Өмнөд Америк, Африк, Зүүн Өмнөд Ази болон Энэтхэгийн хойгт нутагшуулсан.

Бүс нутагт: Булган голын сав.

Хорогдлын шалтгаан: усны чанарын өөрчлөлтийн улмаас амьдрах орчин нь доройтолд орсон.

12. *Carassius gibelio* (Bloch, 1782)

Түгээмэл нэр: Prussian carp (Англи),
Мөнгөлөг хэлтэг (Mongolian)



Бүс нутагт: Анхааралд өртхөөргүй.

Үнэлгээний бодит байдал: Маш өргөн тархалттай том популяци тэмдэглэгдсэн. Популяцийн тоо толгойн бууралт ажиглагдаагүй.

Дэлхийн тархац: Баруун Европ, Орос болон Азид. Баруун Европын ихэнх орнуудад нутагшуулсан.


Бүс нутагт: Онон, Хэрлэн голууд болон Буйр нуур (Амар мөрний сав газар). Оросын Байгаль нуурт нутагшуулсан. Монгол орны хойд хэсэг, Сэлэнгэ мөрөнд өргөн тархсан. Хөвсгөл нуурын зүүн хэсгээр байсан гэх боловч олдоогүй (энэ популяцид үнэлгээ хийгээгүй).

Хорогдлын шалтгаан: Хууль бус агналт (худалдааны).

13. *Chanodichthys erythropterus* (Basilewsky, 1855)

Түгээмэл нэр: Red-fin culter (Англи),
Цагаан догтор (Монгол)

Өмнөх хувилбар: *Culter erythropterus*



Бүс нутагт: Үнэлэх боломжгүй

Үнэлгээний бодит байдал: Дэлхийн популяцийн 1% хүрэхгүй хэсэг нь Монголд тохиолдох бөгөөд бүс нутгийн тархалт Монгол орны нутаг дэвсгэрийн 1% -иас бага хэсгийг эзэлдэг.

Дэлхийн тархац: Улаан мөрний сав газраас (Вьетнам болон Тайван) Амар мөрний сав газар хүртэл (Хятад, Орос, Монгол, Солонгос, Япон).


Бүс нутагт: Буйр нуур (Амар мөрний сав газар).

Хорогдлын шалтгаан: Хууль бус агналт (худалдааны).

14. *Chanodichthys mongolicus* (Basilewsky, 1855)

Түгээмэл нэр: Mongolian culter, Mongolian red-fin
(Англи), Монголын улаан далбаат (Монгол)

Өмнөх хувилбар: *Culter mongolicus*



Бүс нутагт: Үнэлэх боломжгүй

Үнэлгээний бодит байдал: Дэлхийн популяцийн 1% хүрэхгүй хэсэг нь Монголд тохиолдох бөгөөд бүс нутгийн тархалт Монгол орны нутаг дэвсгэрийн 1% -иас бага хэсгийг эзэлдэг.


Дэлхий тархац: Улаан мөрний сав газраас (Вьетнам болон Тайван) Амар мөрний сав газар хүртэл (Хятад, Орос, Монгол, Солонгос, Япон).

Бүс нутагт: Хэрлэн, Халхын гол, Онон голын доод хэсгээр, Буйр нуур (Амар мөрний сав).

Хорогдлын шалтгаан: Хууль бус агналт (худалдааны).

15. *Culter alburnus* Basilewsky, 1855

Түгээмэл нэр: White culter, bleak culter (Англи),
Өлгөр цагаан (Монгол)



Бүс нутагт: Үнэлэх боломжгүй

Үнэлгээний бодит байдал: Дэлхийн популяцийн 1% хүрэхгүй хэсэг нь Монголд тохиолдох бөгөөд бүс нутгийн тархалт Монгол орны нутаг дэвсгэрийн 1% -иас бага хэсгийг эзэлдэг.

Дэлхийн тархац: Улаан мөрний сав газраас (Вьетнам болон Тайван) Амар мөрний сав газар хүртэл (Хятад, Орос, Монгол, Солонгос, Япон).


Бүс нутагт: Хэрлэн, Халхын гол, Онон голын доод хэсгээр, Буйр нуур (Амар мөрний сав).

Хорогдлын шалтгаан: Хууль бус агналт (худалдааны).

16. *Cyprinus rubrofuscus* Lacépède, 1803

Түгээмэл нэр: Asian common carp (Англи),
Булуу цагаан (Монгол)

Ижил нэр: *Cyprinus haematopterus*



Бүс нутагт: Үнэлэх боломжгүй

Үнэлгээний бодит байдал: Дэлхийн популяцийн 1% хүрэхгүй хэсэг нь Моголд тохиолдох бөгөөд бүс нутгийн тархалт Монгол орны нутаг дэвсгэрийн 1% -иас бага хэсгийг эзэлдэг.

Дэлхийн тархац: Амарын савд (Хятад, Орос, Монгол). Лаосын өмнөд хэсгээс Вьетнам хүртэл. Оросод нутагшуулсан.

Бүс нутагт: Онон, Хэрлэн голууд болон Буйр нуур (Амар мөрний сав газар). Сэлэнгэ мөрний сав газар (энэ популяцид үнэлгээ хийгээгүй).

Хорогдлын шалтгаан: Хууль бус агналт (худалдааны); мөн шинээр нутагшуулсан *Carassius carpio* эрлийзсэн учраас эрсдэлтэй болсон.

17. *Eupallasella percunurus* (Pallas, 1814)

Түгээмэл нэр: Lake minnow (Англи),

Нуурын варлан (Монгол)

Өөр хувилбар: *Phoxinus percunurus*

Дэлхийн хэмжээнд: Мэдээлэл дутмаг.

Бүс нутагт: Мэдээлэл дутмаг.


Үнэлгээний бодит байдал: Энэ зүйлийн талаарх тархалтын мэдээлэл хангалттай байгаа хэдий ч популяцийн хэмжээ, хандлага, алтны уурхайн нөлөөллийн мэдээ хангалтгүй байгаа.

Дэлхийн тархац: Хойд мөсөн далайн ай сав, Оросын баруун хэсгээс Колым мөрөн хүртэл; Номхон далайн ай сав, Амар мөрний ай саваас Солонгос, Япон хүртэл. Польш болон Украйнд ‘Устаж болзошгүй’ гэсэн ангилалд бүртгэгдсэн. Италид нутагшуулсан.

Бүс нутагт: Орхон, Сэлэнгэ голын ай сав (Хойд мөсөн далайн ай сав), болон Хэрлэн, Онон голууд, Буйр нуур (Амар мөрний ай сав).

Хорогдлын шалтгаан: Алт олборлолтоос үүдэлтэй амьдрах орчны доройтол.

Санал: Одоогоор *E. percunurus* гэж тодорхойлогдсон газар зүйн хувьд тусгаарлагдсан хэд хэдэн популяци байдаг. Европын популяциуд нь газар зүйн хувьд тусгаарлагдсан байдаг учир тусдаа зүйл байж болох талтай (M. Kottelat, аман мэдээ).




18. *Gnathopogon strigatus* (Regan, 1908)

Түгээмэл нэр: Manchurian gudgeon (Англи),

Сугасан гүрц (Монгол)

Өмнөх хувилбар: *Paraleucogobio strigatu*



Бүс нутагт: Үнэлэх боломжгүй

Үнэлгээний бодит байдал: Дэлхийн популяцийн 1% хүрэхгүй хэсэг нь Монголд тохиолдох бөгөөд бүс нутгийн тархалт Монгол орны нутаг дэвсгэрийн 1% -иас бага хэсгийг эзэлдэг.

Дэлхийн тархац: Амар мөрний ай сав газар (Хятад, Орос, Монгол), Лиао мөрний сав (Хятадын Хойд хэсэг, Солонгос).

Бүс нутагт: Буйр нуур (Амар мөрний ай сав).


Хорогдлын шалтгаан: Тодорхойгүй.

19. *Gobio acutipinnatus* Menschikov, 1939

Түгээмэл нэр: Irtysh gudgeon (Англи),

Ердийн гүрц (Монгол)

Эх хувилбар: *Gobio gobio acutipinnatus*



Бүс нутагт: Үнэлэх боломжгүй

Үнэлгээний бодит байдал: Дэлхийн популяцийн 1% хүрэхгүй хэсэг нь Монголд тохиолдох бөгөөд бүс нутгийн тархалт Монгол орны нутаг дэвсгэрийн 1% -иас бага хэсгийг эзэлдэг.

Дэлхийн тархац: Хятадын Алтай, Монгол, Орос болон Казакстан, Иртыш мөрний сав газрыг багтаана.

Бүс нутагт: Булган голын сав.


Хорогдлын шалтгаан: усны чанарын өөрчлөлтийн улмаас амьдрах орчин нь доройтолд орсон.

20. *Gobio synocephalus* Dybowski, 1869

Түгээмэл нэр: Dog-faced gudgeon (Англи),

Морин гүрц (Монгол)

Дахин тодорхойлсон: *Gobio gobio*



Бүс нутагт: Мэдээлэл дутмаг.

Үнэлгээний бодит байдал: Энэ зүйлийн тархалтын талаарх мэдээлэл тодорхой боловч тус бүс нутгийн тодорхой хэсгүүдэд хорогдож байгаа гэсэн таамаг байгаа. Гэхдээ хорогдолд хүргэж буй шалтгаан тодорхой бус.

Дэлхийн тархац: Амар мөрний сав (Хятад, Орос болон Монгол).


Бүс нутагт: Хэрлэн, Онон голууд, Буйр нуур (Амар мөрний ай сав).

Хорогдлын шалтгаан: Хотын бохир усны хаягдлын нөлөөгөөр бий болсон органик бохирдол болон алт олборлолтын явцад хэрэглэсэн хүнд металлын улмаас амьдрах орчин доройтолд орсон; Буйр нуурын усны түвшин багассанаас амьдрах орчин хомсдон доройтож байгаа,

21. *Gobio soldatovi* Berg, 1914

Түгээмэл нэр: Amur gudgeon (Англи),
Түнгүсийн гүрц (Монгол)

Дахин тодорхойлсон: *Gobio tungussicus*



Бүс нутагт: Мэдээлэл дутмаг.

Үнэлгээний бодит байдал: Тархалт, популяцийн хэмжээ болон хандлагын талаарх мэдээлэл хангалтгүй, хорогдолд хүргэж буй шалтгаан тодорхойгүй.

Дэлхийн тархац: Лена мөрний сав газар (Орос) болон Амар мөрний сав (Хятад, Орос болон Монгол).


Бүс нутагт: Онон голын сав.

Хорогдлын шалтгаан: Тодорхойгүй.

22. *Gobio tenuicorpus* Mori, 1934

Түгээмэл нэр: Eastern whitefin gudgeon (Англи),
Цагаан сэлүүрт гүрц ба Сахалт гүрц (Монгол)

Өмнөх хувилбар: *Gobio albipinnatus*



Бүс нутагт: Үнэлэх боломжгүй

Үнэлгээний бодит байдал: Дэлхийн популяцийн 1% хүрэхгүй хэсэг нь Монголд тохиолдох бөгөөд бүс нутгийн тархалт Монгол орны нутаг дэвсгэрийн 1% -иас бага хэсгийг эзэлдэг.


Дэлхийн тархац: Амар мөрний сав (Хятад, Орос болон Монгол), болон Хятадын зүүн хойд хэсэгт.

Бүс нутагт: Буйр нуур, түүний цутгал голууд (Амарын савд).

Хорогдлын шалтгаан: Тодорхойгүй.

23. *Hemibarbus labeo* (Pallas, 1776)

Түгээмэл нэр: Horse gudgeon (Англи),
Морин загас (Монгол)



Бүс нутагт: Мэдээлэл дутмаг

Үнэлгээний бодит байдал: Хууль бус агналтын улмаас Буйр нуурын популяцийн тоо толгой буурч байгаа. Гэхдээ энэ популяцийн тоо толгойн бууралтыг тодорхойлох хангалттай мэдээлэл байхгүй.


Дэлхийн тархац: Амар мөрнөөс Тингжианг мөрний сав газар хүртэл (Орос, Монгол, Хятад, Солонгос) болон Тайван.

Бүс нутагт: Онон, Хэрлэн голууд болон Буйр нуур (амар мөрний сав).

Хорогдлын шалтгаан: Хууль бус агналт (худалдааны); Буйр нуурын усны түвшин багассанаас амьдрах орчин доройтон хомсдсон .

24. *Hemibarbus maculatus* Bleeker, 1871

Түгээмэл нэр: Spotted horse gudgeon (Англи),
Толбот морин загас (Монгол)



Бүс нутагт: Мэдээлэл дутмаг

Үнэлгээний бодит байдал: Энэ зүйл 1956 оноос хойш тэмдэглэгдээгүй. Цаашдын судалгаагаар энэ зүйл Монголд дахь тархалт, тохиолдоцыг батлах шаардлагатай.

Дэлхийн тархац: Яангце мөрний сав (Хятад), Амар мөрний сав хүртэл (Хятад, Орос, Монгол).


Бүс нутагт: Буйр нуур (Амарын сав).

Хорогдлын шалтгаан: Буйр нуурын усны түвшин багассанаас амьдрах орчин доройтон хомсдсон.

Санал: Энэ зүйл нь хамгийн сүүлд 1956 онд Буйр нуурт тэмдэглэгдсэн (Sokolov, 1983). Сүүлийн үед тодорхой чиглэлийн судалгаа хийгдээгүй тул энэ зүйлийн бүс нутгийн хэмжээнд утсан гэж дүгнэж болохгүй.

25. *Hemiculter leucisculus* (Basilewsky, 1855)

Түгээмэл нэр: Hemiculter (Англи),
Ердийн хавчигас (Монгол)



Бүс нутагт: Үнэлэх боломжгүй

Үнэлгээний бодит байдал: Дэлхийн популяцийн 1% хүрэхгүй хэсэг нь Монголд тохиолдох бөгөөд бүс нутгийн тархалт Монгол орны нутаг дэвсгэрийн 1% -иас бага хэсгийг эзэлдэг.


Дэлхийн тархац: Амарын савд (Хятад, Монгол), Аннам хүртэл (Вьетнам).

Бүс нутагт: Буйр нуур (Амарын сав).

Хорогдлын шалтгаан: Тодорхойгүй.

26. *Ladislavia taczanowskii* Dybowski, 1869

Түгээмэл нэр: Sharp-jawed minnow (Англи),
Тачановын гүрц (Монгол)



Бүс нутагт: Мэдээлэл дутмаг

Үнэлгээний бодит байдал: Тархалт, популяцийн хэмжээ болон хандлагын талаарх мэдээлэл хангалтгүй, хорогдолд хүргэж буй шалтгаан тодорхойгүй.


Дэлхийн тархац: Амар мөрний сав (Хятад, Орос, Монгол), Ялу мөрний сав (Солонгос).

Бүс нутагт: Онон, Балж, Хурх голууд түүний сав газар (Амарын сав).

Хорогдлын шалтгаан: Тодорхойгүй.

27. *Leuciscus baicalensis* (Dybowski, 1874)

Түгээмэл нэр: Siberian dace (Англи),
Шивэр сугас (Монгол)



Бүс нутагт: Анхааралд өртөхөөргүй


Үнэлгээний бодит байдал: Энэ зүйл нь өргөн тархалттай, популяцийн хэмжээ том, популяцийн тоо толгойн бууралт ажиглагдаагүй.

Дэлхийн тархац: Обь мөрнөөс Колым хүүртэл, оросын Енисей мөрний сав.
Бүс нутагт: Сэлэнгэ мөрний сав, Өгий, Тэрхийн Цагаан нуур (Хойд мөсөн далайн ай сав).

Хорогдлын шалтгаан: Хууль бус агналт (худалдааны); алт олборлолтын үйл ажиллагааны улмаас тодорхой газруудад амьдрах орчин нь доройтолд орсон.

28. *Leuciscus dzungaricus* Koch & Paerke, 1998

Түгээмэл нэр: Dzungarian dace (Англи),
Зүүн гарын сугас (Монгол)



Бүс нутагт: Устаж болзошгүй, В1ab(v) болон 2ab(v)

Үнэлгээний бодит байдал: Энэ зүйлийн тархалтын нутгийн нийт хэмжээ нь 5,000 км² талбайгаас бага боловч 500 км² хүрэхгүй талбайд тохиолдож байгаа (В шалгуур). Мөн энэ загас нь Монголд зөвхөн нэг газарт тэмдэглэгдсэн. Хууль бус агналтаар нэлээд хорогдсон, цаашид үржлийн бодгалиудын эзлэх хувь үргэлжлэн буурах хандлагатай байгаа. Бүс нутгийн шалгуурыг ашигласны дараа хамгааллын зэрэглэлд өөрчлөлт ороогүй. Хятадаас популяци нүүдэллэн ирэх нь тохиолддог. Хууль бус агналтын улмаас тоо толгой нь буурч байгаа.


Дэлхийн тархац: Монгол, Хятад. Казакстанд тохиолддог эсэх нь тодорхой бус.

Бүс нутагт: Булган голын адаг.

Хорогдлын шалтгаан: Хууль бус агналт (худалдааны).

29. *Leuciscus idus* (Linnaeus, 1758)

Түгээмэл нэр: Ide (Англи), Бух сугас (Монгол)



Бүс нутагт: Ховордож болзошгүй

Үнэлгээний бодит байдал: Өгий нуурын популяци багасаж байгаа гэж үздэг. Нийт Монгол оронд тохиолдох популяцийн бараг 30% нь хорогдсон гэж тэмдэглэгдсэн (А шалгуур). Тухайн зүйл нь 10 гаруй газарт тохиолдох боловч, түүний тохиолдоцын нутаг дэвсгэр (нуурыг хамруулаад) нь В шалгуурын босго үзүүлэлт болох 2,000 км² нутаг дэсгэртэй ойролцоо юм. Мөн алт олборлолтын үйл ажиллагааны улмаас амьдрах орчин нь үргэлжлэн доройтож байгаа, мөн хэт агналтаас болж Өгий нуур дахь үржлийн насны бодгалиуд тоо толгой үргэлжлэн буурч байгаа зэргээс хамаарч энэ зүйлд В2 шалгуурыг ашиглан үнэлгээ хийхэд 'Эмзэг' гэсэн зэрэглэлд ангилагдаж

байв. Бүс нутгийн шалгуурыг ашигласны дараа хамгааллын зэрэглэлд өөрчлөлт ороогүй учир нь Оросоос Сэлэнгэ рүү нүүдэллэн ирэх шилжилт нэлээд их байдаг. Бохирдлоос болон Оросын нутагт явагдаж байгаа хэт агналтын улмаас тоо толгой нь буурч байгаа гэж үздэг.


Дэлхийн тархац: Райн мөрний сав, Герман, Европыг хөндлөн зүүн тийш Лена мөрний сав газар хүртэл, Оросын зүүн хэсэг, Газар дундын тэнгис рүү цутгах голуудад болон Скандиновын хойд хэсгээр тэмдэглэгддэггүй. Английн Вант Улс, Хойд Америк, Шинэ Зиландад нутагшуулсан.

Бүс нутагт: Сэлэнгэ, Орхон, Туул голууд болон Өгий нуур (Хойд мөсөн далайн ай сав); Булган голын ай сав.

Хорогдлын шалтгаан: Өгий нуурт хийх хууль бус агналт (худалдааны); Туул голын ойролцоох алтны үйл ажиллагааны улмаас амьдрах орчин нь доройтолд орсон.

30. *Leuciscus waleckii* (Dybowski, 1869)

Түгээмэл нэр: Amur ide (Англи),
Амарын сугас (Монгол)



Бүс нутагт: Мэдээлэл дутмаг

Үнэлгээний бодит байдал: Энэ зүйл нь өргөн тархалттай боловч популяцийн тоо, хандлагын таларх мэдээлэл, хорогдолд хүргэж буй шалтгаан тодорхойгүй.

Дэлхийн тархац: Амар мөрнөөс Яангце голын усан сан (Хятад, Орос, Монгол) болон Солонгос.


Бүс нутагт: Хэрлэн, Онон, Халхын голууд болон Буйр нуур (Амарын савд).

Хорогдлын шалтгаан: Хятадын худалдан авах хэрэгцээ дагаж хууль бус агналт нэмэгдэх; Буйр нуурын усны түвшин буурч байгаагаас амьдрах орчин доройтон хомсдож байгаа.

31. *Microphysogobio tungtingensis* (Nichols, 1926)

Түгээмэл нэр: Buir gudgeon (Англи),
Буйр гүрц (Монгол)

Ижил нэр: *Pseudogobio tungtingensis*, *Microphysogobio amurensis*



Бүс нутагт: Мэдээлэл дутмаг

Үнэлгээний бодит байдал: Энэ зүйл нь зөвхөн Буйр нуур болон түүний цутгал голуудад тэмдэглэгдсэн. Популяцийн хэмжээ, хандлага болоод

хорогдлын шалтганы талаарх мэдээлэл хангалтгүй.

Дэлхийн тархац: Амар мөрнөөс Яангце голын усан сан (Хятад, Орос, Монгол)


Бүс нутагт: Буйр нуур, Халхын голын бэлчир (Амарын сав).

Хорогдлын шалтгаан: Буйр нуурын усны түвшин буурч байгаагаас амьдрах орчин хомсдох.

32. *Oreoleuciscus angusticephalus* Bogutskaya, 2001

Түгээмэл нэр: Lake osman, bigmouth osman (Англи), Нохой сугас (Монгол)

Өмнөх нэр: *Oreoleuciscus pewzowi*



Бүс нутагт: Эмзэг, B1ab(v)••

Үнэлгээний бодит байдал: Нутгийн хүмүүс тухайн зүйлийн тоо багасаж буйг тэмдэглэсэн. Гэхдээ, популяцийн бууралтын хэмжээ 30% (А шалгуураар авч үздэг)-д хүрч байна уу, үгүй гэдэг асуудал тодорхой бус байна. Тархац нутгийн хэмжээ 5,000-аас 10,000 км² талбайн хооронд хэлбэлзэж байгаа. Энэ зүйл загас нь 9 газарт тэмдэглэгдсэн. Хэт агналт хийснээр нууранд амьдрах загасны үржлийн насны бодгалийн тоо үргэлжлэн буурч байгаа (В шалгуур).

Хууль цаазанд: Монголын Ан агнуурын тухай хуулинд 4 сарын 15 наас 8 сарын 1 ний хооронд агнахыг хориглосон.


Дэлхийн тархац: Монгол.

Бүс нутагт: Хар Ус, Хар, Ногоон, Хяргас, Ачит, Толбо, Үүрэг нуур (Төв Азийн гадагш урсгалгүй ай сав).

Хорогдлын шалтгаан: Хууль бус агналт (худалдааны).

33. *Oreoleuciscus humilis* Warpachowski, 1889

Түгээмэл нэр: Small osman, dwarf osman (Англи), Давжаа сугас (Монгол)



Бүс нутагт: Эмзэг, B2ab (ii,iii,iv,v)

Үнэлгээний бодит байдал: Тохиолдоц нутгийн хэмжээ 2,000 км² талбайгаас бага (В шалгуур). Энэ зүйл нь Тэс голын 200 км урсах газарт болон хэд хэдэн жижиг нууруудад буюу хоорондоо тусгаарлагдсан долоон газарт хэд хэдэн тасархайтсан тархалттай популяци байдлаар тохиолддог. Энэ популяцийн 50 орчим хувь нь устах аюул нүүрлэсэн хэтэрхий жижиг популяциас тогтдог гэж үнэлэгдсэн (В шалгуур). Алтны уурхайн үйл ажиллагааны үр дүнд

үүссэн бохирдол нь амьдрах орчны чанарыг бууруулсан.

Хууль цаазанд: Монголын Ан агнуурын тухай хуулинд 4 сарын 15 наас 8 сарын 1 ний хооронд агнахыг хориглосон.


Дэлхийн тархац: Терекол нуур (оросын Тува), Обь мөрний салаа голууд (Орос), Монгол.

Бүс нутагт: Таацын Цагаан, Бөөн Цагаан, Орог, Сангийн далай нуур, Байдраг, Онги, Тэс, Хүнгүй, Түйн, Тарна, Хүйтэн гол, болон Говийн нууруудын хөндий, Увс нуурын цутгал Нарийны гол (Төв Азийн гадагш урсгалгүй ай сав), Сэлэнгэ мөрөнд цутгах голууд, Орхон голын цутгал голууд (Хойд мөсөн далайн ай сав).

Хорогдлын шалтгаан: Говийн хөндийн нуурууд хатаж, ширгэснээс амьдрах орчны хомсдолд хүрсэн; Алт олборлолтонд ашигласан хүнд металлын улмаас амьдрах орчин нь доройтсон.

34. *Oreoleuciscus potanini* (Kessler, 1879)

Түгээмэл нэр: Potanin's osman (Англи), Алтайн сугас (Монгол)



Бүс нутагт: Анхааралд өртөхөөргүй

Үнэлгээний бодит байдал: Тохиолдоцын хэр хэмжээг болон тархацын нутаг дэвсгэртэй харьцуулбал энэ зүйлийн тархалт нь маш том орон зайг эзэлдэг. Үүнийг В шалгуурын хүрээнд авч үзвэл босго үзүүлэлтээс дээгүүр байсан. Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг нь хамгаалалттай газар нутагт хамрагддаг ч орон нутгийн түвшинд хууль бус агналт хийх тохиолдол байдаг. Гэхдээ, энэ нь популяцийн хэмжээг өөрчлөх хэмжээний сөрөг нөлөө үзүүлдэггүй.

Хууль цаазанд: Монголын Ан агнуурын тухай хуулинд 4 сарын 15 наас 8 сарын 1 ний хооронд агнахыг хориглосон.


Дэлхийн тархац: Тува улсын Оби мөрний эхний Бий, Катунь, Чуя голын саваар (Оросын Холбооны Улс) болон Монголд

Бүс нутагт: Хар, Хар Ус, Ногоон, Дөргөн, Айраг, Хяргас, Бөөн цагаан, Орог, Таацын Цагаан, Хангай, Хүй, Сангийн далай, Тэлмэн, Хотон, Хоргон, Хоромдог, Даян нуур, Ховд, Завхан, Тэс, Хүнгүй, Байдраг гол (Төв Азийн гадагш урсгалгүй ай сав).

Хорогдлын шалтгаан: Хууль бус агналт (худалдааны).

35. *Phoxinus phoxinus* (Linnaeus, 1758)

Түгээмэл нэр: Common minnow (Англи),
Ердийн варлан ба Нүцгэн жараа (Монгол)



Бүс нутагт: Анхааралд өртөхөөргүй.

Үнэлгээний бодит байдал: Маш өргөн тархалттай, том популяци тэмдэглэгдсэн. Популяцийн тоо толгойн бууралт ажиглагдаагүй.

Дэлхийн тархац: Европ (Португаль, Мальт, Ирланд, Исланд болон Албанийг оролцуулахгүй), Оросын зүүн хэсэг рүү, Монгол, Япон, Солонгос.


Бүс нутагт: Дэлгэр мөрөн, Идэр, Чулуут, Хануй, Орхон, Ерөө, Хараа, Цох, Хүдэр, Туул болон Шишхэд гол, Хөвсгөл, Тэрхийн Цагаан, Өгий нуур, Дархадын хотгорын нуурууд (Хойд мөсөн далайн ай сав), болон Булган голын сав, Онон, Хэрлэн, Халхын, Оршуун гол болон Буйр нуур (Амарын сав).

Хорогдлын шалтгаан: Тодорхойгүй.

Санал: Монгол дахь популяци нь морфологийн хувьд алслагдсан 2 бүлэг (ө.х. Сэлэнгийн бүлэг, Амарын ай савын) тохиолддог (Kottelat, хэвлэгдэж буй). Хятадын эрдэмтэн Булганы популяцийг *P. phoxinus ujmonensis* / Kashenko, 1899/ хэмээх алслагдсан салбар зүйл гэж үзсэн. Харин Kottelat үүнийг Ердийн варлангийн (*P. ujmonensis*)-гийн алслагдсан зүйл гэж тэмдэглэсэн (Kottelat, хэвлэгдэж буй).

36. *Pseudaspius leptocephalus* (Pallas, 1776)

Түгээмэл нэр: False asp (Англи),
Улаан живэрт (Монгол)



Бүс нутагт: Мэдээлэл дутмаг.

Үнэлгээний бодит байдал: Зүйлийн тархалт, популяцийн хэмжээ, хандлага, хорогдлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй.


Дэлхийн тархац: Амар мөрний сав (Хятад, Орос, Монгол).

Бүс нутагт: Онон, Буйр нуур, Халх голын адаг (Амарын савд).

Хорогдлын шалтгаан: хууль бус агналт (худалдааны).

37. *Pseudorasbora parva* (Temminck & Schlegel, 1846)

Түгээмэл нэр: *Pseudorasbora* (Англи),
Амарын хөөлөнхэй (Монгол)
Ижил нэр: *Leuciscus parvus*



Бүс нутагт: Мэдээлэл дутмаг.

Үнэлгээний бодит байдал: Зүйлийн тархалт, популяцийн хэмжээ, хандлага, хорогдлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй.


Дэлхийн тархац: Амар мөрний сав (Хятад, Монгол) Вьетнамын хойд хэсэг хүртэл, Солонгос, Хятад, Тайван. Европод нутагшуулсан, Австри, Франц, Герман, Итали, Польш, Орос болон Английн Вант улс

Бүс нутагт: Онон, Хэрлэн, Улз, Халх болон Оршуун гол, Буйр нуур (Амарын сав).

Хорогдлын шалтгаан: Тодорхойгүй.

38. *Rhodeus sericeus* (Pallas, 1776)

Түгээмэл нэр: Amur bitterling (Англи),
Халбаган жараа (Монгол)



Бүс нутагт: Мэдээлэл дутмаг.

